

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ДААТГАЛЫН ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/****НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ****1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь даатгалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, даатгуулагч болон хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Даатгалын тухай хууль тогтоомж

2.1.Даатгалын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэх гэрээний харилцааг Иргэний хууль болон энэ хуулиар зохицуулна.

3.2.Даатгалын брокер, даатгалын төлөөлөгчийн эрх зүйн байдлыг Даатгалын зуучлалын тухай хуулиар зохицуулна.

3.3.Даатгалын үйл ажиллагаатай холбогдсон ерөнхий харилцааг энэ хуулиар, тусгайлан зохицуулсан хуультай тохиолдолд нарийвчилсан харилцааг тухайн хуулиар зохицуулна.

3.4.Төрөөс хэрэгжүүлж буй нийгмийн болон эрүүл мэндийн албан журмын даатгалын харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёо

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."даатгалын үйл ажиллагаа" гэж даатгалын гэрээний дагуу даатгагч нь даатгалын тохиолдол үүсэхэд учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй үйл ажиллагааг;

4.1.2."давхар даатгалын үйл ажиллагаа" гэж даатгагч нь даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн дахин даатгах даатгалын үйл ажиллагааг;

4.1.3."хамтын даатгал" гэж даатгалын эрсдэлийг хэд хэдэн даатгагч хамтран даатгах даатгалын үйл ажиллагааг;

4.1.4."амьдралын даатгал" гэж даатгуулагч аливаа шалтгааны улмаас нас барах, хөдөлмөрийн чадвараа алдахтай холбогдох болон эрүүл мэндийн, хуримтлалын, тэтгэврийн, аннуити зэрэг даатгалын үйл ажиллагааг;

4.1.5."ердийн даатгал" гэж хөрөнгийн даатгал, хариуцлагын даатгал зэрэг амьдралын даатгалд тооцогдохгүй даатгалын үйл ажиллагааг;

4.1.6."заавал даатгал" гэж Монгол Улсын хуульд заавал даатгуулахаар тусгагдсан даатгалын үйл ажиллагааг;

4.1.7."даатгагч" гэж энэ хуулийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанийг;

4.1.8."даатгуулагч" гэж өөрийн болон даатгагдсан этгээдийн ашиг сонирхлын төлөө даатгалын зүйлээ даатгуулж, даатгагчтай гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийг;

4.1.9."даатгалын тохиолдол" гэж даатгуулсан зүйлд учирсан хохирол, тохиролцсон нөхцөл бүрдэхийг;

4.1.10."даатгалын хураамж" гэж даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг;

4.1.11."даатгалын нөхөн төлбөр" гэж даатгалын гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгийг;

4.1.12."даатгалын мэргэжлийн оролцогч" гэж даатгагч, даатгалын брокер, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгч, актуарч, андеррайтер, даатгалын байгууллагад аудит хийх эрх бүхий этгээд болон Санхүүгийн зохицуулах хорооноос /цаашид "Хороо" гэх/ даатгалын мэргэжлийн оролцогч гэж үзсэн этгээдийг;

4.1.13."актуарч" гэж даатгагчийн төлбөрийн чадварын түвшин, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан үнэлж, эдийн засаг, математикийн тооцоо, судалгааны үндсэн дээр үйл ажиллагаа явуулах актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх авсан этгээдийг;

4.1.14."даатгалын хохирол үнэлэгч" гэж даатгагч, даатгуулагчийн нэрийн өмнөөс даатгалын гэрээтэй холбоотой нэхэмжлэлийг хянан шалгах, бодит хохирлыг тогтоох, талуудын хооронд хэлэлцээ хийх чиг үүргийг хэрэгжүүлэх, ийнхүү хэрэгжүүлсний төлөө цалин хөлс болон бусад төлбөр авах даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх эрх авсан этгээдийг;

4.1.15."толгой даатгагч" гэж хамтын даатгалын эрсдэлийг хамтран даатгах саналыг бусад даатгагчид тавьж, хамтын даатгалын гэрээнд эрсдэлийн тодорхой хувийг хүлээн авахаас гадна уг даатгалыг зохион байгуулах үүрэг хүлээх даатгагчийг;

4.1.16."гадаадын зохицуулах байгууллага" гэж даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий гадаад улсын байгууллагыг;

4.1.17."эрх бүхий албан тушаалтан" гэж Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-д заасан этгээдийг;

4.1.18."холбогдох этгээд" гэж даатгагчийн хувьцааны хяналтын багцыг эзэмшдэг аливаа иргэн, хуулийн этгээд болон Компанийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-д заасан нэгдмэл сонирхолтой этгээдийг.

4.2.Тэтгэврийн хуримтлал үүсгэн түүнээс хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа нь энэ хуулийн 4.1.1-д нэгэн адил хамаарна.

4.3.Бодит хохирлоос үл хамааран тодорхой итгэлцүүр буюу бусад аргачлалыг ашиглан даатгагчийн хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг томъёогоор дундажлан тооцоолж гаргадаг үйл ажиллагаа энэ хуулийн 4.1.1-д нэгэн адил хамаарна.

5 дугаар зүйл. Гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүний даатгал

5.1.Гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа хөрөнгө, амь нас, эрүүл мэнд, хариуцлага, ашиг сонирхлыг Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн нэгэн адил нөхцөлөөр даатгуулах эрхтэй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ДААТГАЛЫН АНГИЛАЛ, ХЭЛБЭР, ТӨРӨЛ

6 дугаар зүйл. Даатгалын ангилал, хэлбэр, төрөл

6.1.Даатгалыг амьдралын даатгал, ердийн даатгал гэж ангилна.

6.2.Энэ хуулийн 4.1.4-т заасан амьдралын даатгалын үйл ажиллагаанд хамаарах дараах даатгалын үйл ажиллагааг ердийн даатгагч эрхэлж болно.

6.2.1.гэнэтийн осол, гэмтлийн улмаас хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учрахад даатгагчаас даатгуулагч эсхүл даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий гэнэтийн осол, эмчилгээний даатгал,

6.2.2.даатгуулагч гадаадад зорчих үед гэнэтийн ослоор эсвэл гадаадад зорчих үеийн даатгалын гэрээнд тусгагдсан өвчнөөр нас барах, хөдөлмөрийн чадвараа алдах даатгал;

6.3.Даатгал нь сайн дурын болон заавал гэсэн хэлбэртэй байна.

6.4.Даатгалын хэлбэр тус бүр нь төрөлтэй байх бөгөөд сайн дурын даатгалын төрлийг Хороо тогтооно.

7 дугаар зүйл. Заавал даатгал

7.1.Монгол Улсын хуульд заавал даатгуулахаар тусгасан даатгалын үйл ажиллагааг заавал даатгалын хэлбэрт хамруулах бөгөөд заавал даатгалтай холбогдох харилцааг тухайн хуулинд тусгана.

7.2.Энэ хуулийн 7.1-д заасан заавал даатгалын үйл ажиллагааг тусгайлсан хуулиар нарийвчлан зохицуулаагүй бол заавал даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, заавал даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг Хороо, холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталсан журмаар нарийвчлан зохицуулна.

7.3. Заавал даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгагч нар хамтран заавал даатгалын хураамжийн тодорхой хувиар байгаль орчин, нийгэмд ээлтэй ногоон бизнес, үйл ажиллагааг дэмжихэд зориулсан санг байгуулна.

8 дугаар зүйл. Даатгалын хураамж

8.1.Хураамжийн хэмжээ нь актуар тооцоололд үндэслэнэ.

8.2.Сайн дурын даатгалын хураамжийн хэмжээг даатгагч тогтооно.

9 дүгээр зүйл. Даатгалын нөхөн төлбөр

9.1. Даатгагч нь хууль болон гэрээнд заасан нөхцөлийн дагуу энэ хуулийн 9.4-т заасан баримтыг үндэслэн даатгуулагчид даатгалын нөхөн төлбөрийг олгоно.

9.2. Даатгалын гэрээнд заасан тохиолдолд нөхөн төлбөрийг даатгуулагчийн буруугаас хохирсон гуравдагч этгээдэд шууд олгож болно.

9.3. Даатгуулагч нас барсны дараа даатгалын тохиолдол үүссэн бол даатгалын нөхөн төлбөрийг түүний хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчид олгоно.

9.4. Даатгалын нөхөн төлбөрийг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр ирүүлсэн дараах баримтыг үндэслэн олгоно:

9.4.1. нөхөн төлбөр нэхэмжлэгчийн гаргасан өргөдөл;

9.4.2. гэрээнд заасан бол холбогдох мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, тодорхойлолт;

9.4.3. хууль тогтоомжид заасан бусад баримт.

9.5. Даатгагч гэрээнд заагаагүй болон даатгалын тохиолдолд хамааралгүй баримт бичгийг даатгуулагчаас шаардаж болохгүй.

9.6. Хороо даатгалын нөхөн төлбөр олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журам баталж болно.

9.7. Даатгагч дараах үндэслэлээр нөхөн төлбөрийг бүрэн буюу түүний зарим хэсгийг олгохоос татгалзаж болно:

9.7.1. даатгуулагч даатгалын нөхөн төлбөр авах зорилгоор санаатайгаар хохирол учруулсан буюу даатгалын тохиолдол бий болох нөхцөл, орчныг зохиомлоор бүрдүүлсэн нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон;

9.7.2. даатгуулагч даатгалын тохиолдлын талаар даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;

9.7.3. даатгалын гэрээнд заагаагүй эрсдэлээс үүдэн бий болсон хохирол;

9.7.4. гарсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн;

9.7.5. хууль тогтоомж болон гэрээнд заасан бусад үндэслэл.

9.8. Даатгагч нь нөхөн төлбөр олгохоос татгалзсан үндэслэлээ тодорхой гаргаж, даатгуулагчид бичгээр, эсхүл даатгуулагчийн зөвшөөрлөөр цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

9.9. Даатгагч нь энэ хуулийн 9.8-д заасны дагуу цахим хэлбэрээр мэдэгдсэн бол тухайн мэдээллээ архив үүсгэн хадгална.

9.10. Даатгалын хууль тогтоомж, даатгалын гэрээнд заасан бол буруутай этгээдээс төлбөр нэхэмжлэх даатгуулагчийн эрх нь даатгалын гэрээний дагуу олгогдсон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан зардлын хэмжээгээр даатгагчид шилжинэ.

9.11. Даатгалын тохиолдлын улмаас хөрөнгө бүрэн устсан, сүйрсэн, дахин сэргээгдэх боломжгүй болсон тохиолдолд учирсан хохирлыг даатгагч бүрэн барагдуулсан бол даатгуулагч нь уг хөрөнгийг даатгагчид шилжүүлнэ.

10 дугаар зүйл. Даатгагчийн эрх, үүрэг

10.1. Даатгагч дараах эрх эдэлнэ:

10.1.1. энэ хуулийн 9.7-д заасан үндэслэлийн дагуу даатгалын нөхөн төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн олгохоос татгалзах;

10.1.2. даатгуулагчийн эрх, үүрэг нь шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд даатгагч гэрээнд өөрчлөлт оруулах саналыг шинэ эзэмшигчид тавих;

10.1.3. даатгуулагч хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, эсхүл түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;

10.1.4. даатгуулагчид олгосон нөхөн төлбөр болон түүнтэй холбогдон гарсан зардлыг буруутай этгээдээс нэхэмжлэн авах эрхийг шилжүүлэн авах.

10.2. Даатгагч дараах үүрэг хүлээнэ:

10.2.1.даатгалын тохиолдол болсон үед нөхөн төлбөрийг хууль болон гэрээгээр тохиролцсон хугацаа, хэмжээнд олгох;

10.2.2.даатгуулагчийн эрсдэлийг үнэлэх, түүнд тохирсон даатгалын гэрээний нөхцөлийг боловсруулж, санал болгох, энэ талаар даатгуулагчид танилцуулах;

10.2.3.даатгалын хууль тогтоомж, даатгалын гэрээний нөхцөлийн талаар даатгуулагчид даатгалын гэрээ байгуулагдахаас өмнө танилцуулах, даатгалын тохиолдлын улмаас үүссэн хохирлыг шуурхай чирэгдэлгүй барагдуулах үүднээс даатгуулагчид үнэн зөв, бодит мэдээлэл өгөх;

10.2.4.Монгол Улсын хуулиар зөвшөөрснөөс бусад нөхцөлд даатгуулагчийн талаарх мэдээ, материалын нууцыг задруулахгүй байх;

10.2.5.даатгалын эрсдэлийн улмаас учирч болох хохирлын хэмжээг багасгах зорилгоор даатгуулагчийн авсан арга хэмжээний өртгийг даатгуулагчид нөхөн төлөх;

10.2.6.даатгуулагч нас барсан тохиолдолд түүний эрх, үүргийг хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчид нь шилжүүлэх;

10.2.7.гэрээний хугацаанд даатгуулагч эрх зүйн чадамжгүй нь тогтоогдвол түүний эрх, үүргийг хэрэгжүүлэхийн тулд хууль ёсны асран хамгаалагчийг шүүхээр тогтоолгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

10.2.8.энэ хууль болон Хорооноос баталсан журмын дагуу санхүүгийн болон бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэх;

10.2.9.даатгалын брокер, даатгалын төлөөлөгчөөс бусад этгээдэд даатгалын борлуулалтын хөлс, орлогын шимтгэл, шан харамжийг олгохгүй байх;

10.2.10.өөрийн томилсон даатгалын төлөөлөгчийн буруутай үйл ажиллагаанаас үүссэн хохирлыг хариуцах;

11 дүгээр зүйл. Даатгуулагчийн эрх, үүрэг

11.1.Даатгуулагч дараах эрх эдэлнэ:

11.1.1.даатгагчаа чөлөөтэй сонгох;

11.1.2.даатгалын тохиолдол болсон үед гэрээний нөхцөлийн дагуу нөхөн төлбөр олгохыг даатгагчаас шаардах;

11.1.3.даатгагч хууль болон гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, эсхүл гэрээнд өөрчлөлт оруулахыг шаардах;

11.1.4.даатгуулагчийн эрх, үүрэг шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд шинэ эзэмшигч гэрээнд өөрчлөлт оруулах саналыг даатгагчид тавих;

11.2.Даатгуулагч дараах үүрэг хүлээнэ:

11.2.1.даатгалын хураамжийг хууль болон гэрээнд заасан хугацаанд даатгагчид төлөх;

11.2.2.даатгалын зүйлийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тохиолдол болсон үед хохирлыг багасгах зорилгоор бололцоотой арга хэмжээг авах, даатгагчид нэн даруй мэдэгдэх;

11.2.3.даатгалын гэрээ байгуулах болон даатгалын нөхөн төлбөртэй холбогдсон баримт материал, мэдээллийг даатгагчид үнэн зөв гаргаж өгөх;

11.2.4.даатгуулагч болон түүний эрх бүхий этгээд нь нөхөн төлбөрөөс өөр аливаа шан харамж, хөлсийг шууд болон бусад этгээдээр дамжуулан авахгүй байх;

11.2.5.даатгалын зүйлийн хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг шаардлагатай тохиолдолд даатгагчид танилцуулах, шалгуулах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨРӨӨС ЗОХИЦУУЛАХ

12 дугаар зүйл. Даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

12.1.Даатгалын бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь даатгалын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 12.1.1.даатгалын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах
- 12.1.2.Засгийн газрыг даатгалын бодлогын зөвлөгөөгөөр хангах;
- 12.1.3.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

13 дугаар зүйл. Даатгалын зохицуулах байгууллага

13.1.Даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хянах эрхийг даатгалын асуудал хариуцсан Хороо хэрэгжүүлнэ.

13.2.Хороо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 13.2.1.даатгалын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;
- 13.2.2.энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан даатгагчийн даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих;
- 13.2.3.даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;
- 13.2.4.даатгалын дотоод, гадаад зах зээлийг судлах, даатгалын талаарх албан ёсны мэдээлэл гаргах;
- 13.2.5.даатгалын үйл ажиллагаатай холбогдох нэгдсэн бүртгэл хөтлөх;
- 13.2.6.захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, журам, заавар, аргачлал /цаашид "даатгалын журам" гэх/ баталж, түүний хэрэгжилтэд нь хяналт тавих;
- 13.2.7.энэ хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор аливаа этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх;
- 13.2.8.даатгуулагчийн эрхийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах;
- 13.2.9.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

13.3.Хороо нь даатгагч дампуурах болон даатгалын үйл ажиллагаатай холбоотой хууль бус үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй хохирлоос даатгуулагч болон олон нийтийг хамгаалах зорилгоор байнгын хяналтыг хэрэгжүүлнэ.

14 дүгээр зүйл. Даатгалын журам

14.1.Даатгалын салбарын үйл ажиллагааг Хорооноос баталсан даатгалын журмаар зохицуулна.

14.2.Хороо даатгалын салбарын үйл ажиллагааг хянах, зохицуулах хүрээнд дараах Даатгалын журмыг батална:

- 14.2.1.энэ хуульд заасан тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргах, түүнд тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт;
- 14.2.2.даатгалын мэргэжлийн оролцогчид, түүний үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт;
- 14.2.3.даатгагчийн эрсдэлийн удирдлага, төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих;
- 14.2.4.даатгалын нөөц болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, хөрөнгө оруулалтад байршуулах, түүнд хяналт тавих;
- 14.2.5.салбар, төлөөлөгчийн газар нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа явуулах даатгагчид тавигдах нөхцөл, шаардлага;

14.2.6.даатгалын мэргэжлийн оролцогчоос энэ хуульд заасны дагуу санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, мэдээ гаргаж, тайлагнах;

14.2.7.даатгагчаас үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг бусдад шилжүүлэх болон нэгтгэх үйл ажиллагаа;

14.2.8.давхар даатгалын болон даатгалын эрсдэл шилжүүлэх бусад арга хэрэгслүүдийг зохицуулах;

14.2.9. цахим хэлбэрээр даатгалын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих;

14.2.10.даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх;

14.2.11.Дампуурлын тухай хууль, Компанийн тухай хуулиас гадуур даатгагчийг татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг явуулах;

14.2.12.даатгагчийн үйл ажиллагааг түр зогсоох нөхцөл;

14.2.13.тохиромжтой этгээдийг тодорхойлох, тохиромжтой бус этгээдийг бүртгэх,

14.2.14 даатгалын залилангаас урьдчилан сэргийлэх;

14.2.15.энэ хууль болон холбогдох журамд заасан мэдээллийг олон нийтэд хүргэх;

14.2.16.даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд бизнесийн ёс зүйг мөрдөх;

14.2.17.заавал даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих;

14.2.18.хууль тогтоомжид заасан бусад.

14.3.Хороо даатгалын зах зээлийг хөгжүүлэх, боловсронгуй болгох, даатгагчийн үйл ажиллагааг зохистой явуулах зорилгоор тусгайлан даатгалын журмыг өөрийн бүрэн эрхийн хүрээнд баталж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

15 дугаар зүйл. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах эрх бүхий этгээд

15.1.Дараах этгээд даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргах эрхтэй:

15.1.1.Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компани;

15.1.2.гадаад улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан компани.

16 дугаар зүйл. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэх тухай өргөдөл гаргах

16.1.Энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан этгээд нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлөө Хороонд гаргана.

16.2.Өргөдлийг бичгээр болон цахим хэлбэрээр гаргах бөгөөд түүнд эрхлэх даатгалын ангилал, хэлбэр, төрлийг зааж, Хорооноос тогтоосон загварын дагуу энэ хууль болон Даатгалын журамд заасан баримт бичгийг хавсаргаж ирүүлнэ.

16.3.Хороо шаардлагатай гэж үзсэн нэмэлт мэдээлэл, баримт бичгийг өргөдөл гаргагчаас шаардаж болно.

17 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах

17.1.Хороо дараах шаардлагыг хангасан өргөдөл гаргагчид тусгай зөвшөөрлийг олгох бөгөөд тухайн даатгалын хэлбэр, төрлөөс хамааран нэмэлт шаардлага тавьж болно:

17.1.1.өргөдөл гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан, өргөдөл гаргагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг этгээд болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6.а-д заасан этгээд нь даатгалын үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээд бол;

17.1.2.өргөдөл гаргагч нь тусгай зөвшөөрлийг олгосны дараа энэ хууль болон Даатгалын журмыг дагаж мөрдөх бүрэн боломжтой гэдэг нь нотлогдож байна гэж үзвэл;

17.1.3.тухайн даатгалын үйл ажиллагааг эрхлэхэд өргөдөл гаргагчийн удирдлага, зохион байгуулалт тохиромжтой гэж үзвэл;

17.1.4.тухайн даатгалын үйл ажиллагааг эрхлэхэд өргөдөл гаргагчийн санхүүгийн эх үүсвэр хууль ёсны орлогоос бүрдсэн, хангалттай гэж үзвэл;

17.1.5.тусгай зөвшөөрөл олгох нь нийтийн болон даатгуулагчийн ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж үзвэл.

17.2.Хороо даатгагчийн үйл ажиллагааны цар хүрээ, тусгай зөвшөөрлийн хэлбэр, төрлөөс хамааран тусгай зөвшөөрөлд тавигдах нөхцөл шаардлагыг хэдийд ч өөрчлөн тогтоож болно.

17.3.Хороо даатгалын ангиллаар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг давхардуулан олгохгүй.

17.4.Тусгай зөвшөөрлийг бичгээр олгох бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана:

17.4.1.тусгай зөвшөөрлийг олгосон байгууллагын нэр;

17.4.2.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр хаяг;

17.4.3.эрхлэх даатгалын үйл ажиллагаа, ангилал, хэлбэр, төрөл;

17.4.4.тусгай зөвшөөрлийн дугаар, олгосон огноо;

17.4.5.тусгай зөвшөөрөл олгосон байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга/тэмдэг/;

17.5.Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгох бөгөөд уг зөвшөөрөл нь энэ хуулийн 79, 80 дугаар зүйлд заасны дагуу түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл хүчин төгөлдөр байна.

17.6.Хороо өргөдөл гаргагчид тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан, эсхүл тусгай зөвшөөрөл олгохыг зөвшөөрсөн боловч даатгалын тодорхой хэлбэр, төрлийн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөөгүй бол энэ тухай бичгээр мэдэгдэж, татгалзсан үндэслэлийг заана.

17.7.Хороо дараах үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана:

17.7.1.энэ хуулийн 17.1-д заасан шаардлагыг хангаагүй;

17.7.2.Даатгалын журамд заасан баримт бичгийг бүрэн ирүүлээгүй, ирүүлсэн баримт бичиг нь шаардлагыг хангаагүй;

17.7.3.хуульд заасан бусад үндэслэл.

17.8.Хороо өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 45 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

18 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг хориглох

18.1.Энэ хуулийн 18.2-т зааснаас бусад этгээд Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлгүйгээр Монгол улсын нутаг дэвсгэрт даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

18.2.Даатгагчтай гэрээ байгуулан давхар даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа гадаад улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдэд энэ хуулийн 18.1 дэх хэсэг хамаарахгүй.

18.3.Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.

19 дүгээр зүйл. Даатгагчийн даатгах зүйл

19.1. Аливаа этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт буй хөрөнгө, амь нас, эрүүл мэнд, хариуцлага, ашиг сонирхлыг гагцхүү энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан даатгагчид даатгуулна.

19.2.Гадаадын даатгагчтай давхар даатгалын гэрээ байгуулах даатгагчид дараахь тохиолдолд энэ хуулийн 19.1 дэх хэсэг хамаарахгүй:

19.2.1.энэ хуулийн 53.2-т заасны дагуу давхар даатгалын төлөвлөгөөг Хороонд хүргүүлсэн бол;

19.2.2.энэ хуулийн 53.3-т заасны дагуу тухайн гэрээнд давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага хамаарахгүй байхаар Хорооноос тогтоосон бол.

ТАВДУГААР БҮЛЭГ ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА

20 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн байгууллага

20.1.Даатгалын мэргэжлийн байгууллага нь даатгалын мэргэжлийн оролцогчдоос бүрдсэн гишүүнчлэлтэй, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн үйл ажиллагаа болон ёс зүйн нийтлэг журмыг тогтоох, гишүүдийнхээ чадавхыг дээшлүүлэх, даатгалын зах зээлийг хөгжүүлэх, тогтвортой байдлыг хангах үндсэн зорилго бүхий Хороонд бүртгүүлсэн хуулийн этгээд байна.

20.2.Даатгалын мэргэжлийн байгууллага нь дараах төрөлтэй байна.

20.2.1.Заавал даатгалын холбоо;

20.2.2.Даатгалын мэргэжлийн холбоо.

21 дүгээр зүйл. Даатгалын мэргэжлийн байгууллагын эрх, үүрэг

21.1.Даатгалын мэргэжлийн байгууллага нь дараах нийтлэг эрхтэй:

21.1.1. даатгалын зах зээлийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр төрийн байгууллагын боловсруулсан хууль тогтоомж, дүрэм, журмын төсөлд санал өгөх;

21.1.2.гишүүдийнхээ үйл ажиллагаанд баримтлах нийтлэг журам, мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, заавар, зөвлөмжийг баталж, хэрэгжилтийг хангуулах;

21.1.3.өөрийн дүрэм, журмаар тогтоосон хүрээнд гишүүдийнхээ үйл ажиллагааны зөрчлийн талаар холбогдох байгууллагад мэдээлэх;

21.1.4.Хорооноос нийтийн эрх зүйн гэрээгээр шилжүүлсэн эрх.

21.2.Даатгалын мэргэжлийн байгууллага нь дараах нийтлэг үүрэгтэй:

21.2.1.Хорооноос өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх;

21.2.2.Хорооноос олгосон эрхийн хүрээнд холбогдох үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Хороо болон эрх бүхий бусад байгууллагад шуурхай мэдээлэх, тайлагнах;

21.2.3.олон нийтийг төөрөгдүүлэх худал мэдээллийг тарааж, даатгалын зах зээлийн нэр хүндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх үйл ажиллагаа хийхгүй байх;

21.2.4.үйл ажиллагааны онцлог, цар хүрээнээс хамааран өөрийн гишүүдийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, гишүүдийн мэргэжлийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах;

21.2.5.Хороо болон бусад эрх бүхий байгууллагаас өгсөн үүрэг, чиглэл.

22 дугаар зүйл. Заавал даатгалын холбоо

22.1.Заавал даатгалын холбоо нь дараах чиг үүрэг хэрэгжүүлнэ.

22.1.1.энэ хуулийн 70 дугаар зүйлд заасан даатгалын мэдээллийн санг удирдах, түүний аюулгүй байдлыг хангах;

22.1.2.даатгалын зах зээлийн судалгаа, шинжилгээ хийх, тайлан гаргах;

22.1.3.заавал даатгалын эрсдэл, хураамж болон үнэлгээний доод хэмжээг тогтоох талаар судалгаа хийх, итгэлцүүр тогтоох саналаа Хороонд хүргүүлэх;

22.1.4.даатгалын тохиолдлыг бууруулах чиглэлээр заавал даатгалын сургалт, сурталчилгаа явуулах;

22.1.5.заавал даатгалын сангийн үйл ажиллагааг удирдан, зохион байгуулах;

22.1.6.Хорооноос зөвшөөрсөн бусад чиг үүрэг.

22.2.Хорооноос заавал даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгагч нь Заавал даатгалын холбоонд гишүүн болох үүрэгтэй.

22.3.Заавал даатгалын холбоо нь хууль тогтоомжид нийцсэн, Хорооноос зөвшөөрсөн дүрэмтэй байна.

22.4.Заавал даатгалын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд даатгагч, даатгуулагч, Хороо болон даатгалын бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллийг оролцуулах ба удирдах зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнийг Хороо батална.

22.5.Заавал даатгалын холбооны хөрөнгө дараах үндсэн эх үүсвэрээс бүрдэнэ:

22.5.1.эхлэлтийн хөрөнгө;

22.5.2.заавал даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагч бүрээс төвлөрүүлэх хөрөнгө;

22.5.3. мэдээллийн санг төлбөртэй ашиглуулсны орлого;

22.5.4. судалгаа шинжилгээ, актуар тооцоолол хийсний хөлс;

22.5.5. хуульд заасан бусад эх үүсвэр.

22.6.Хороо нь заавал даатгалын холбооны үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам, зааврыг баталж, уг холбооны үйл ажиллагаанд хяналт тавина.

22.7.Заавал даатгалын холбоо нь үйл ажиллагаагаа жил бүр Хороонд тайлагнаж, олон нийтэд мэдээлнэ.

23 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн холбоо

23.1. Даатгалын мэргэжлийн холбоо нь даатгалын мэргэжлийн сургалт явуулах, давтан сургах, зөвлөгөө өгөх болон Хорооноос зөвшөөрсөн бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.

23.2. Хороо нь дараах шаардлагыг хангасан холбоог Даатгалын мэргэжлийн холбоогоор бүртгэнэ.

23.2.1.даатгалын мэргэжлийн холбооны гишүүд нь Хорооны зохицуулалттай этгээд байх;

23.2.2.даатгалын мэргэжлийн холбооны эрхлэх үйл ажиллагааны чиглэлд хамаарах зохицуулалттай этгээдийн тавиас дээш хувийг гишүүнээр элсүүлсэн байх;

23.2.3. гишүүддээ мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах техник хэрэгслийн болон хүний нөөцийн чадамжтай байх;

23.2.4. сургалтын хөтөлбөр боловсруулж, Хороогоор батлуулсан байх;

23.2.5. мэргэжлийн ёс зүйн хариуцлага хүлээлгэх дотоод хяналтын бүтэцтэй байх.

23.3. Энэ хуулийн 23.2-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд Хороо даатгалын мэргэжлийн холбоог бүртгэхээс татгалзана.

23.4. Даатгалын мэргэжлийн холбоо нь Хороонд үйл ажиллагаагаа тайлагнах ба Хороо хяналт тавина.

23.5. Хороо энэ хуулийн 20.1-д заасан даатгалын мэргэжлийн байгууллагын нэрсийн жагсаалт, түүнд орсон өөрчлөлтийг Даатгалын журамд заасны дагуу тухай бүр нийтэд мэдээлнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХӨРӨНГӨ, САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨЛБӨРИЙН ЧАДВАР

24 дүгээр зүйл. Даатгагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ

24.1. Даатгагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны үйл ажиллагааны орлогоос бүрдүүлсэн мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний доод хэмжээг даатгалын ангилал, давхар даатгалын онцлогийг харгалзан Хороо тогтооно. Хувь нийлүүлсэн хөрөнгийг зээлийн хөрөнгөөр бүрдүүлэхийг хориглоно.

24.2. Энэ хуулийн 24.1-д заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээнд хүрэх боломжит хугацааг даатгагчид олгоно.

24.3. Даатгагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө энэ хуулийн 24.1-д заасан хэмжээнд хүрэхгүй болсон тохиолдолд даатгагч Хороонд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

24.4. Даатгагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 10 буюу түүнээс дээш хувийг бүрдүүлэгч нь хуулийн этгээд байх тохиолдолд Мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6.а-д заасан “эцсийн өмчлөгч” этгээдийг Хороонд мэдэгдэнэ.

25 дугаар зүйл. Даатгагчийн хувьцаа

25.1. Энэ хуулийг дагаж мөрдсөн өдрөөс хойш даатгалын компанийн гаргасан бүх хувьцааны төлбөрийг мөнгөн хэлбэрээр хийнэ.

25.2. Даатгагчид Компанийн тухай хуулийн 44 дүгээр зүйл хамаарахгүй.

26 дугаар зүйл. Даатгагчийн хувьцааны шилжилтэд тавих хяналт

26.1. Даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж буй этгээд нь өөрийн өмчлөл, эзэмшилд буй хөрөнгийг Хорооны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад худалдах, шилжүүлэх, барьцаалах зэргээр захиран зарцуулах, эсхүл захиран зарцуулахыг бусдад зөвшөөрөхийг хориглоно.

26.2. Аливаа этгээд Хорооноос бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран шууд буюу шууд бусаар эзэмшихийг хориглоно.

26.3. Даатгагч нь Хорооноос бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх болон багасгах үр дагаварт хүргэх хувьцаа гаргах, хуваарилах, хувьцаа эзэмшигчдийн эзлэх хувийг бууруулах буюу нэмэгдүүлэх үр дагаварт хүргэх хэлцэл хийхийг хориглоно.

26.4. Даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй эзэмшихийг хүсэгч нь ийнхүү эзэмших тохиромжтой этгээд гэж үзсэн тохиолдолд Хороо хүсэлт гаргагчид зөвшөөрөл олгоно.

26.5.Хороо энэ хуулийн 26.4-т заасан зөвшөөрөл олгохдоо шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл, шаардлага тавьж болно.

26.6.Хүсэлт гаргагчийг тохиромжтой этгээд мөн эсэхтэй холбогдох тодорхойлолтыг гаргахад даатгалын мэргэжлийн байгууллага дэмжлэг үзүүлж болно.

27 дугаар зүйл. Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт

27.1.Даатгагч нь дараах төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг хангасан байна:

27.1.1.Даатгалын журамд заасан хэмжээнээс багагүй;

27.1.2.энэ хуулийн 27.2-т заасны дагуу Хорооноос тогтоосон хэмжээнээс багагүй.

27.2.Хороо даатгалын үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээнээс хамааран тухайн даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг энэ хуулийн 27.1.1-д заасан хэмжээнээс дээгүүр тогтоож болно.

27.3.Энэ хуулийн 27.2-т заасан төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтэд хүрэх боломжит хугацааг даатгагчид олгоно.

27.4.Даатгагчийн төлбөрийн чадвар нь энэ хуулийн 27.1-д заасан үзүүлэлтэд хүрэхгүй болсон тохиолдолд даатгагч Хороонд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

28 дугаар зүйл. Даатгалын нөөц

28.1.Даатгагч нь гэрээний явцад үүссэн болон үүсч болзошгүй үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор даатгалын хураамж, нэхэмжлэлийн онцлогийг харгалзан даатгалын нөөцүүдийг даатгалын төрөл тус бүрээр байгуулж, мөнгөн хөрөнгөөр бүрдүүлнэ.

28.2.Даатгалын нөөцийн ангилал, зориулалт, хэмжээ, нөөц бүрдүүлэх болон хөрөнгө оруулалтад байршуулах нөхцөлийг Даатгалын журмаар тогтооно.

28.3.Энэ хуулийн 28.1-д заасан даатгалын нөөцийг тусгайлан бүртгэлд тусгах бөгөөд нөөцийн хөрөнгийг хооронд нь шилжүүлэн зарцуулахыг хориглоно. Нөөцийн бүрдүүлэлт, зарцуулалт нь Хорооны хяналтад байна.

28.4.Даатгагчийн нөөцөд төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ энэ хуулийн 28.2-т заасан хэмжээнд хүрэхгүй болсон тохиолдолд даатгагч Хороонд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

28.5.Даатгалын нөөцийн хөрөнгийг Даатгалын журамд зааснаас өөрөөр зарцуулахыг хориглоно.

29 дүгээр зүйл. Ногдол ашиг хуваарилах нөхцөл

29.1.Ногдол ашиг хуваарилсны дараа дараах нөхцөлийн аль нэг нь үүсэхээр бол хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй:

29.1.1.даатгагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь энэ хуулийн 24.1-д заасан хэмжээнд хүрэхгүй;

29.1.2.даатгагчийн төлбөрийн чадвар энэ хуулийн 27.1-д заасан шалгуур үзүүлэлтийг хангаж чадахгүй;

29.1.3.даатгалын нөөц нь энэ хуулийн 28.2-т заасан хэмжээнд хүрэхгүй.

30 дугаар зүйл. Урьдчилгаа болон зээлтэй холбоотой хязгаарлалт

30.1.Даатгагч нь энэ хуулийг дагаж мөрдсөн өдрөөс хойш дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

30.1.1.өөрийн үнэт цаасыг төлбөрийн баталгаа болгож урьдчилгаа авах;

30.1.2.холбогдох этгээдэд аливаа сангаас зээл олгох;

30.1.3.аливаа этгээдэд барьцаагүй зээл олгох;

30.1.4.аливаа этгээдийн бусдаас авсан зээл болон бусад үүргийн гүйцэтгэлд баталгаа, батлан даалт гаргах;

30.1.5.даатгагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон нөөцийн мөнгөн хөрөнгийг холбогдох этгээд болон түүний үүсгэн байгуулсан хуулийн этгээдэд байршуулах, хөрөнгө оруулах.

30.2.Энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу ногдол ашиг хуваарилахад энэ хуулийн 30.1 дэх хэсэг хамаарахгүй.

31 дүгээр зүйл. Даатгагчийн санхүүгийн чадавхид тавих хяналт

31.1.Хороо даатгагчийн санхүүгийн чадавхийг үнэлэх шалгуур тогтоон, хяналт, шалгалт хийж болно.

31.2.Энэ хуулийн 31.1-д заасны дагуу тогтоосон шалгуурын тухай Хороо даатгагчид бичгээр мэдэгдэнэ.

32 дугаар зүйл. Заавал даатгалын баталгаат сан

32.1.Даатгагч дампуурсан, түүний улмаас заавал даатгалын даатгуулагч хохирох эрсдэлээс хамгаалах зорилгоор заавал даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий даатгагч нар хамтран заавал даатгалын баталгаат санг байгуулна.

32.2.Энэ хуулийн 32.1-д заасан сан нь мөнгөн хөрөнгийн сан байна.

32.3.Энэ хуулийн 32.1-д заасан заавал даатгалын баталгаат сангийн удирдлагыг Заавал даатгалын холбоо хэрэгжүүлнэ.

32.4.Заавал даатгалын баталгаат сангийн хөрөнгийг төвлөрүүлэх, удирдах, түүнийг захиран зарцуулах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах журмыг Заавал даатгалын холбооны саналыг харгалзан Хороо батална.

32.5.Даатгагч дампуурах, түүний улмаас даатгуулагч хохирох эрсдэлээс хамгаалах зорилгоор хэд хэдэн даатгагч нар хамтран сайн дурын даатгалын баталгаат санг байгуулж болно.

ДОЛДУГААР БҮЛЭГ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, АУДИТ

33 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлт болон санхүүгийн тайлан

33.1.Дараах хуулийн этгээд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Даатгалын журамд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана:

33.1.1.даатгагч;

33.1.2.энэ хуулийн 20.2.1-д заасан Заавал даатгалын холбоо.

33.1.3.энэ хуулийн 59.1.2-т заасан хөндлөнгийн хохирол үнэлэгч;

33.2.Хороо энэ хуулийн 33.1-д заасан хуулийн этгээдийн нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг, санхүүгийн тайланг болон бусад баримт бичгийн агуулга, хэлбэрийг тогтооно.

33.3.Санхүүгийн тайлангийн баримт бичиг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-д болон энэ хуулийн 33.2-т заасны дагуу Хорооноос тогтоосон баримт бичгээс бүрдэнэ.

33.4.Энэ хуулийн 33.1-д заасан хуулийн этгээд нь нягтлан бодох бүртгэлийн баримт бичгээ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан хугацаагаар хадгалах бөгөөд хадгалах газрын хаягийг Хороонд бичгээр мэдэгдэнэ.

34 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэлийн стандарт мөрдөх

34.1.Энэ хуулийн 33.1-д заасан хуулийн этгээд нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг дагаж мөрдөнө.

35 дугаар зүйл. Жил бүрийн санхүүгийн тайлан

35.1.Энэ хуулийн 33.1-д заасан хуулийн этгээд нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Даатгалын журамд заасан бусад бичиг баримтын хамт дараа оны эхний сард багтаан Хороонд хүргүүлнэ.

35.2.Энэ хуулийн 33.1.1 болон 33.1.2-т заасан этгээд нь аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангаа дараа оны нэгдүгээр улиралд багтаан Хороонд хүргүүлнэ.

35.3.Энэ хуулийн 35.1, 35.2-т заасан тайланг Хороонд ирүүлээгүй тохиолдолд санхүүгийн тайланг өгөөгүйд тооцно.

36 дугаар зүйл. Улирал тутмын тайлан

36.1.Энэ хуулийн 33.1-д заасан хуулийн этгээд нь улирал тутмын санхүүгийн тайлангаа дараа сарын 20-ны өдрийн дотор Хороонд тушаана.

36.2.Даатгалын журамд заасан баримт бичгийг ирүүлээгүй тохиолдолд санхүүгийн тайланг өгөөгүйд тооцно.

37 дугаар зүйл. Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагаа

37.1.Энэ хуулийн 33.1.1 болон 33.1.2-т заасан хуулийн этгээд нь санхүүгийн тайландаа заавал аудит хийлгэнэ.

37.2.Санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээд /цаашид “аудитын байгууллага” гэх/ дараах шаардлагыг хангасан байна:

37.2.1.Аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй;

37.2.2.санхүүгийн тайланг баталгаажуулах эрхийг Хорооноос авсан.

37.3.Хороо энэ хуулийн 37.2-т заасан эрх бүхий аудитын байгууллагын нэрсийн жагсаалт болон түүнд өөрчлөлт орсон тухай бүр Даатгалын журамд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

37.4.Энэ хуулийн 33.1.1 болон 33.1.2-т заасан хуулийн этгээд нь аудитын байгууллагыг үйл ажиллагаа явуулах нөхцөл, боломжоор хангана.

37.5.Энэ хуулийн 33.1.1 болон 33.1.2-т заасан хуулийн этгээд нь аудитын байгууллагатай гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоногийн дотор Хороонд бичгээр мэдэгдэнэ.

38 дугаар зүйл. Аудитын тайлан

38.1.Аудит хийх хуулийн этгээд нь өөрийн баталгаажуулсан дэлгэрэнгүй тайлан, түүний талаарх эцсийн дүгнэлтийг Даатгалын журамд заасны дагуу энэ хуулийн 33.1.1 болон 33.1.2-т заасан этгээдэд хүргүүлнэ.

38.2.Хороо шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 33.1.1 болон 33.1.2-т заасан этгээдээс аудитын тайлан гаргаж өгөхийг хэдийд ч шаардаж болно.

39 дүгээр зүйл. Аудит хийх хуулийн этгээдийн үүрэг

39.1.Энэ хуулийн 33.1.1 болон 33.1.2-т заасан хуулийн этгээдийн баримт материалд үндэслэн гаргасан дараах дүгнэлтийн талаар аудитын байгууллага нь Хороонд нэн даруй мэдэгдэнэ:

39.1.1.төлбөрийн чадваргүй болсон буюу төлбөрийн чадваргүй болж болзошгүй байгаа;

39.1.2.даатгалын үйл ажиллагаатай холбоотой гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдсэн байж болзошгүй;

39.1.3.даатгагч энэ хуулийн 24-30 дугаар зүйлийг ямар нэг хэлбэрээр зөрчсөн гэж үзвэл;

39.1.4.энэ хууль, бусад хууль тогтоомж, Даатгалын журмыг ноцтойгоор зөрчсөн гэж үзвэл.

39.2.Энэ хуулийн 33.1.1 болон 33.1.2-т заасан хуулийн этгээд нь аудитын байгууллагатай байгуулсан гэрээгээ цуцалсан, эсхүл аудитын байгууллага өөрөө ажиллах боломжгүй гэдгээ мэдэгдэж чөлөөлөгдсөн тохиолдолд аудитын байгууллага нь Хороонд дараах асуудлаар мэдээлэл өгнө:

39.2.1.гэрээ цуцалсан буюу чөлөөлөгдсөн тухай, түүний үндэслэлийн талаар;

39.2.2.энэ хуулийн 39.1-д заасан дүгнэлт гаргасан тохиолдолд энэ тухай.

39.3.Хороо аудитын байгууллагаас аудитын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, нэмэлт материал шаардаж болно.

39.4.Аудитын байгууллага болон аудитын байгууллага байсан этгээд нь энэ хуулийн 38 дугаар зүйлд заасан тайлан болон өөрийн зөв гэж үзсэн бусад мэдээллээр Хороог хангасны төлөө түүнийг мэргэжлийн ёс зүйн дүрэм болон хууль тогтоомж зөрчсөн гэж үзэхгүй бөгөөд түүнд эрүүгийн болон бусад хариуцлага ногдуулахгүй.

40 дүгээр зүйл. Хороо аудит хийх хуулийн этгээдийг томилох

40.1.Энэ хуулийн 33.1.1 болон 33.1.2-т заасан хуулийн этгээд нь энэ хуулийн 37.1-д заасны дагуу аудитын байгууллагатай гэрээ хийгээгүй бол Хороо томилж болно.

40.2.Энэ хуулийн 40.1-д заасны дагуу томилогдсон аудитын байгууллага нь энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

40.3.Энэ хуулийн 40.1-д заасны дагуу Хорооноос томилсон аудитын хуулийн этгээдийн аудитын үйл ажиллагааны зардлыг энэ хуулийн 33.1.1 болон 33.1.2-т заасан этгээд хариуцна.

41 дүгээр зүйл. Компанийн нэгдлийн гишүүдийн нягтлан бодох бүртгэлийн тайланг шаардах

41.1.Энэ хуулийн 33.1.1 болон 33.1.2-т заасан хуулийн этгээд нь компанийн нэгдлийн гишүүн бол Хороо даатгагчаас тухайн нэгдлийн гишүүн аль ч этгээдийн санхүүгийн болон компанийн нэгдлийн нэгдсэн тайланг шаардаж болно.

41.2.Хороо энэхүү тайланг энэ хуулийн 33.1.1 болон 33.1.2-т заасан хуулийн этгээдийн гэрээ хийсэн, эсхүл өөрийн томилсон аудитын байгууллагаар баталгаажуулахыг шаардаж болно.

41.3.Энэ хуулийн 41.1-д заасан компанийн нэгдлийн тайлангийн агуулга, хэлбэрийг Хороо тогтоож болно.

НАЙМДУГААР БҮЛЭГ

АКТУАРЧ, АКТУАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ТАЙЛАН

42 дугаар зүйл. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох

42.1.Хороо актуарчаар ажиллахад тохирох мэргэжил, дадлага туршлага бүхий Монгол Улсын болон гадаад улсын иргэнд актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгоно.

42.2.Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох ажиллагааг Даатгалын журмын дагуу хэрэгжүүлнэ.

42.3.Хороо энэ хуулийн 42.1-д заасны дагуу эрх авсан актуарчийн нэрсийн жагсаалт, түүний өөрчлөлтийг Даатгалын журамд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

43 дугаар зүйл. Актуарчийг томилохтой холбоотой даатгагчийн үүрэг

43.1.Даатгагч нь заавал актуарчтай байх бөгөөд актуарч нь энэ хуулийн 42.1-д заасны дагуу Хорооноос эрх авсан этгээд байна.

43.2.Даатгагч нь өөрийн актуарчийг томилсон болон чөлөөлсөн тухай бүрт Хороонд ажлын 5 хоногт бичгээр мэдэгдэнэ.

43.3.Актуарчаар томилогдсон этгээд үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон бол ийнхүү боломжгүй болсноос хойш ажлын 30 хоногийн дотор даатгагч өөр актуарчийг томилно.

44 дүгээр зүйл. Актуарчийн дагаж мөрдөх стандарт

44.1.Актуарч нь өөрийн үйл ажиллагаандаа Даатгалын журамд заасан актуарын стандартыг дагаж мөрдөнө.

45 дугаар зүйл. Актуарын хяналт шалгалт, тайлан

45.1.Хороо даатгагчийн санхүүгийн байдлын талаархи шаардлагатай гэж үзсэн асуудлыг актуарчаар шалгуулах болон актуарын тайлан гаргаж өгөхийг даатгагчаас шаардаж болно.

45.2.Хороо актуарын хяналт шалгалтыг даатгагчийн томилсон, эсхүл өөрийн томилсон актуарчаар гүйцэтгүүлж болно.

45.3.Актуарч нь Даатгалын журамд заасан агуулга, хэлбэрийн дагуу хяналт шалгалтын тайлан бэлтгэнэ.

45.4.Энэ хуулийн 45.2-т заасан актуарын хяналт шалгалтын тайланг дараа оны 03 дугаар сарын 05-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

45.5.Энэ хуулийн 45.1-д заасан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх болон тайлан бэлтгэхтэй холбогдсон зардлыг даатгагч хариуцна.

46 дугаар зүйл. Актуарчийн эрх

46.1.Актуарч нь дараах эрхтэй байна:

46.1.1.актуарын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг шалгах;

46.1.2.даатгагчийн талаарх шаардлагатай мэдээлэл, баримт бичиг гаргаж өгөх, асуултад хариулахыг даатгагч, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтнаас шаардах.

46.2.Актуарч нь даатгагчийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцож, актуарын хяналт шалгалтын тайлан болон бусад асуудлаар санал, дүгнэлт гарган, танилцуулж болно.

46.3.Актуарч нь дараах асуудлыг Хороонд мэдэгдэж болно:

46.3.1.энэ хуулийн 46.1.1-д заасан мэдээлэл, баримт бичгийг шалгахад даатгагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр актуарчид дэмжлэг үзүүлэхээс татгалзсан, бусад хэлбэрээр саад учруулсан тухай;

46.3.2.даатгагч, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь шаардлагатай мэдээлэл баримт бичиг гаргаж өгөх, асуултад хариулахаас татгалзсан тухай.

47 дугаар зүйл. Актуарчийн үүрэг

47.1.Актуарч нь даатгагчийн баримт материалд үндэслэн гаргасан дараах дүгнэлтийн талаар Хороонд нэн даруй мэдэгдэнэ:

47.1.1.даатгагч нь энэ хууль, бусад хууль тогтоомж, Даатгалын журмыг зөрчсөн, эсхүл зөрчсөн байж болзошгүй;

47.1.2.даатгагч хууль тогтоомж зөрчсөн нь даатгуулагчийн эрх ашигт ноцтой нөлөөлнө гэж үзсэн.

47.2.Актуарч нь даатгагчийн санхүүгийн байдал, нөөц, төлбөрийн чадвар, даатгагч болон даатгуулагчийн ашиг сонирхолд нөлөөлж болох аливаа асуудлаар шаардлагатай арга хэмжээ авах талаар даатгагчид мэдэгдэх үүрэгтэй.

47.3.Хороо даатгагчийн санхүүгийн байдлын талаарх шаардлагатай гэж үзсэн асуудлыг актуарчаар шалгуулах болон актуарын тайлан гаргаж өгөхийг даатгагчаас шаардаж болно.

47.4.Актуарч энэ хуулийн 47.2-т заасны дагуу даатгагчид мэдэгдсэн бөгөөд тогтоосон хугацаанд даатгагч ямар нэг арга хэмжээ аваагүй бол энэ тухай Хороонд нэн даруй мэдэгдэнэ.

47.5.Даатгагч актуарчтай байгуулсан гэрээгээ цуцалсан, эсхүл өөрөө ажиллах боломжгүй гэдгээ мэдэгдэж чөлөөлөгдсөн тохиолдолд актуарч нь Хороонд дараах асуудлаар мэдээлэл өгнө:

47.5.1.гэрээ цуцалсан буюу чөлөөлөгдсөн тухай, түүний үндэслэлийн талаар;

47.5.2.энэ хуулийн 47.1, 47.4-т заасан мэдээллийн тухай.

47.6.Актуарч болон актуарч байсан этгээд тайлан болон энэ хуулийн 47 дугаар зүйлд заасан өөрийн зөв гэж үзсэн бусад мэдээллээр Хороог хангасны төлөө түүнийг мэргэжлийн ёс зүйн дүрэм болон хууль тогтоомж зөрчсөн гэж үзэхгүй бөгөөд түүнд эрүүгийн болон бусад хариуцлага ногдуулахгүй.

48 дугаар зүйл. Хороо актуарчийг томилох

48.1.Даатгагч нь актуарчийг томилоогүй бол Хороо энэ хуулийн 42.1-д заасан актуарын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдийг актуарчаар томилно.

48.2.Энэ хуулийн 48.1-д заасны дагуу томилогдсон актуарч нь даатгагчийн актуарчийн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

48.3.Энэ хуулийн 48.1-д заасан актуарчийг томилохтой холбогдсон зардлыг даатгагч хариуцна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ДАВХАР ДААТГАЛ БОЛОН ДААТГАЛЫН ЭРСДЭЛ ШИЛЖҮҮЛЭХ БУСАД АРГА ХЭРЭГСЭЛ

49 дүгээр зүйл. Давхар даатгал

49.1.Даатгагч нь гэрээний дагуу хүлээсэн үүргээ дараах даатгагчид давхар даатгуулж болно:

49.1.1.энэ хуулийн дагуу давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгагчид;

49.1.2.энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл аваагүй гадаад улсын давхар даатгагчид.

49.2.Даатгагч нь даатгалын гэрээний дагуу хүлээсэн үүргээ давхар даатгуулах тохиолдолд давхар даатгалд шилжүүлэх даатгалын үнэлгээний 10-аас доошгүй хувийг энэ хуулийн 49.1.1-д заасан даатгагчид даатгуулна.

50 дугаар зүйл. Даатгалын эрсдэл шилжүүлэх бусад арга хэрэгсэл

50.1.Даатгагч нь энэ хуулийн 49.1-д зааснаас гадна дараах хэлбэрээр даатгалын эрсдэлийг шилжүүлж болно:

50.1.1.хамтын даатгал хэлбэрээр даатгалын эрсдэлийг хэд хэдэн даатгагчтай хамтран;

50.1.2.даатгалын эрсдэл шилжүүлэх уламжлалт бус санхүүгийн хэрэгсэл ашиглан;

50.1.3.хуульд нийцсэн бусад арга хэрэгсэл.

51 дүгээр зүйл. Хамтын даатгал

51.1.Толгой даатгагч эсхүл даатгалын зуучлагч нь хамтын даатгалын үйл ажиллагааг зохион байгуулах ба толгой даатгагч эсхүл даатгалын зуучлагчийн зохион байгуулалтын энэхүү үүрэг нь хамтын даатгалын гэрээ дуусгавар болсоноор зогсоно.

51.2.Даатгагчид хүлээн авсан эрсдэлийн хэмжээгээр энэ хууль болон Даатгалын журамд заасан даатгалын нөөцийг байгуулна.

51.3.Даатгалын тохиолдлын үед даатгагч бүр хүлээн авсан эрсдэлийн хувь хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

51.4.Хамтын даатгалын үйл ажиллагааны нарийвчилсан зохицуулалтыг Даатгалын журмаар тогтоож болно.

52 дугаар зүйл. Даатгалын эрсдэлийг шилжүүлэх уламжлалт бус санхүүгийн хэрэгсэл

52.1.Даатгагч нь даатгалын эрсдэлийг шилжүүлэх уламжлалт бус санхүүгийн хэрэгслийг ашиглан даатгалын эрсдэлийг хөрөнгийн зах зээлд гаргаж болно.

52.2.Энэ хуулийн 52.1-д заасан эрсдэл шилжүүлэх уламжлалт бус санхүүгийн хэрэгслийг ашиглах үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг Хороо батална.

53 дугаар зүйл. Даатгагчийн төлөвлөгөө, тайлан

53.1.Даатгагч энэ хуулийн 49.1, 50.1-д заасан давхар даатгалын болон даатгалын эрсдэлээ шилжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөтэй байна.

53.2.Даатгагч нь энэ хуулийн 53.1-д заасан төлөвлөгөө болон төлөвлөгөөний тайланг Даатгалын журмын дагуу боловсруулж, Хороонд хүргүүлнэ.

53.3.Хороо тухайн төрлийн давхар даатгалын гэрээнд энэ хуулийн 53.1-д заасан төлөвлөгөөг боловсруулахад тавигдах шаардлага хамаарахгүй байхаар бичгээр тогтоож болно.

АРАВДУГААР БҮЛЭГ

ДААТГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНД ТАВИГДАХ ХЯЗГААРЛАЛТ

54 дүгээр зүйл. Даатгагч зөвхөн даатгалын үйл ажиллагаа эрхлэх

54.1.Даатгагч нь Монгол Улсад болон гадаад улсад гагцхүү даатгалын үйл ажиллагаа болон түүнтэй холбоотой үйл ажиллагаа эрхэлнэ.

54.2.Даатгагчийн эрхлэх даатгалтай холбоотой үйл ажиллагааг Даатгалын журмаар тодорхойлж болно.

55 дугаар зүйл. Тодорхойгүй хэлцлээс зайлсхийх

55.1.Даатгагчийн байгуулсан хариуцлагын хэмжээ, эсхүл дээд хэмжээ нь тодорхойгүй даатгалын гэрээ энэ хуулийн 55.2-т зааснаас бусад тохиолдолд хүчин төгөлдөр бус байна.

55.2.Энэ хуулийн 55.1-д үл хамаарах даатгалын гэрээний хэлбэр, төрлийг Даатгалын журмаар тогтоож болно.

56 дугаар зүйл. "Даатгал" гэсэн нэр томъёог хэрэглэх, хязгаарлах

56.1.Даатгагч нь оноосон нэртэй байх бөгөөд уг нэрийн ард "даатгал" гэсэн үгийг заавал хэрэглэнэ.

56.2.Энэ хуульд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчээс бусад этгээд "даатгал", эсхүл "даатгал" гэсэн үгний төрөл үг, орчуулга үг хэрэглэх, даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа, эсхүл уг үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан гэсэн сэтгэгдэл төрүүлэхүйц нэр томъёо ашиглах болон тэдгээртэй адилтгах бусад үйлдэл хийхийг хориглоно.

57 дугаар зүйл. Даатгагчийн ерөнхий захиргааны хаяг

57.1.Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан даатгалын компанийн ерөнхий захиргаа нь Монгол Улсад байрлах бөгөөд даатгагч нь ерөнхий захиргааныхаа хаягийг Хороонд мэдэгдэнэ.

57.2.Даатгагч нь ерөнхий захиргааныхаа хаягийг өөрчилбөл ажлын 5 хоногийн дотор Хороонд мэдэгдэнэ.

58 дугаар зүйл. Салбар, төлөөлөгчийн газар нээх

58.1.Даатгагч нь өөрийн салбар, төлөөлөгчийн газраа гадаад улсын нутаг дэвсгэрт нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа явуулахдаа Хороонд бүртгүүлнэ.

58.2.Гадаадын даатгагч Хорооноос бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

58.3.Гадаадын даатгагч Хорооноос бичгээр зөвшөөрөл аваагүй тохиолдолд аливаа этгээд гадаадын даатгагчийг төлөөлж дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

58.3.1.даатгалын үйл ажиллагаа явуулах зорилгоор сурталчилгаа, ухуулга хийх, эсхүл ийм зорилгоор албан байр нээж ажиллуулах;

58.3.2.салбар, төлөөлөгчийн газар нээх, ажиллуулах.

58.4.Хороо энэ хуулийн 58.1-д заасны дагуу бүртгэл явуулахдаа даатгагчаас нэмэлт мэдээлэл, баримт шаардаж болно.

58.5.Хороо энэ хуулийн 58.2-т заасан зөвшөөрөл олгохдоо тодорхой нөхцөл, шаардлага тавьж болох бөгөөд эдгээр нөхцөл, шаардлагаа хэдийд ч өөрчилж болно.

59 дүгээр зүйл. Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа

59.1.Хороо дараах этгээдэд даатгалын хохирлыг шалгах, бодит хохирлын хэмжээг тогтоох чиг үүрэг бүхий даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгоно:

59.1.1.даатгагчийн томилсон хохирол үнэлэгч;

59.1.2.хөндлөнгийн хохирол үнэлэгч.

59.2.Хороо даатгалын хохирол үнэлэгчээр ажиллахад тохирох мэргэжил, дадлага туршлага бүхий Монгол Улсын болон гадаад улсын иргэнд энэ хуулийн 59.1.1-д заасан эрхийг, хуулийн этгээдэд энэ хуулийн 59.1.2-т заасан эрхийг олгоно.

59.3.Даатгагч нь энэ хуулийн 59.1.1-д заасан хохирол үнэлэгчийг томилсон болон чөлөөлсөн тухай бүрт Хороонд ажлын 5 хоногт бичгээр мэдэгдэнэ.

59.4.Энэ хуулийн 59.1.1-д заасан хохирол үнэлэгч нь даатгалын тохиолдол болсон нөхцөлд тухайн даатгагчийн нэрийн өмнөөс даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагааг эрхэлж, даатгалын хохирлын үнэлгээг гаргана.

59.5.Дараах тохиолдолд энэ хуулийн 59.1.2-т заасан хөндлөнгийн хохирол үнэлэгчид хандан үнэлгээг хийлгэж болно.

59.5.1.Даатгуулагч нь энэ хуулийн 59.1.1-д заасан даатгагчийн томилсон хохирол үнэлэгчийн үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүй бол;

59.5.2.Мэргэжлийн ур чадвар шаардлагатай, нарийн төвөгтэй байдлаар хийгдэх хохирол үнэлгээний хувьд даатгуулагч хүсэлт гаргасан.

60 дугаар зүйл. Даатгалын хохирол үнэлэгчийн эрх, үүрэг

60.1.Даатгалын хохирол үнэлэгч нь дараах эрх эдэлнэ:

60.1.1.хохирол үнэлгээний үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой шаардлагатай мэдээ мэдээлэл, баримт бичгийг шалгах, даатгуулагчаас шаардах;

60.1.2.шаардлагатай тохиолдолд талуудаас нэмэлт материал шаардах.

60.1.3.хууль тогтоомжид заасан бусад эрх.

60.2. Даатгалын хохирол үнэлэгч нь дараах үүрэгтэй:

60.2.1.Даатгалын тохиолдлыг нарийвчлан шалгаж хохирол үнэлгээний тайлан эсхүл тэдгээртэй адилтгах баримт бичиг үйлдэх;

60.2.2.Хохирол үнэлгээний тайланг холбогдох журамд заасан хугацаанд талуудад танилцуулах;

60.2.3.Хохирлын үнэлгээг үнэн зөв, бодитой, мэргэжлийн ёс зүйтэй гүйцэтгэх.

61 дүгээр зүйл. Цахим хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх

61.1.Даатгалын салбарт оролцогчид үйл ажиллагаагаа цахим хэлбэрээр эрхэлж болох бөгөөд цахим хэлбэрийн онцлог, цар хүрээнээс хамааран шаардлагатай тохиолдолд Хорооноос зөвшөөрөл олгосны үндсэн дээр тухайн үйл ажиллагааг зах зээлд нэвтрүүлнэ.

61.2.Цахим хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх, түүний зөвшөөрөл олгох, хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор Хороо журам баталж болно.

61.3.Даатгалын салбарт оролцогчид цахим хэлбэрээр үйл ажиллагаа явуулах тохиолдолд энэ талаарх нарийвчилсан төлөвлөгөөг бизнес төлөвлөгөөнд тусгаж ажиллана.

62 дугаар зүйл. Эрх бүхий албан тушаалтныг томилох

62.1.Даатгагч, Заавал даатгалын холбоо болон энэ хуулийн 59.1.2-т заасан хөндлөнгийн хохирол үнэлэгч хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан нь Хорооноос баталсан Даатгалын журамд заасан тохиромжтой этгээд байна.

62.2.Хороо энэ хуулийн 62.1-т заасан этгээдийг тухайн албан тушаалд тохирно гэж үзвэл эрх бүхий албан тушаалтнаар томилох зөвшөөрөл олгоно.

62.3.Энэ хуулийн 62.2-т заасан эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх дуусгавар болсон, эсхүл хүсэлтээрээ чөлөөлөгдсөн тохиолдолд энэ хуулийн 62.1-т заасан даатгагч, Заавал даатгалын холбоо болон хөндлөнгийн хохирол үнэлэгч нь энэ тухай ажлын 5 хоногийн дотор Хороонд бичгээр мэдэгдэнэ.

63 дугаар зүйл. Даатгалын зуучлагчаас бусад этгээдэд аливаа шан харамж төлөхийг хориглох

63.1. Даатгагч нь даатгалын зуучлагчаас бусад этгээдэд даатгалын борлуулалтын урамшуулал, орлогын шимтгэл зэрэг аливаа хэлбэрийн шан харамж, хөлс олгохыг хориглоно.

64 дүгээр зүйл. Мэдээллийг өөрчлөх

64.1. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэж байгаа этгээд, эсхүл даатгагч болон бусад этгээдээс энэ хууль, Даатгалын журамд заасны дагуу гаргаж буй аливаа зөвшөөрөл, эрх хүссэн өргөдлийг хэлэлцэн шийдвэрлэхээс өмнө Хороонд ирүүлсэн мэдээлэл, баримтад өөрчлөлт орвол зөвшөөрөл хүссэн этгээд энэ тухай нэн даруй бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ДААТГАГЧИЙН ЗАСАГЛАЛ

65 дугаар зүйл. Даатгагчийн засаглалын тогтолцоо

65.1. Даатгагч нь түүний хувьцаа эзэмшигч болон хөрөнгө оруулагчийн эрх ашгийг нэн тэргүүнд тавин, бусад оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэж, даатгалын үйл ажиллагаа явуулахдаа ил тод нээлттэй байх зарчмыг баримтална.

65.2. Даатгагчийн засаглалын тогтолцоонд дотоод хяналт тогтмол хийгддэг байна.

65.3. Даатгагчийн төлөөлөн удирдах зөвлөл нь даатгагчийн зохистой засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, дотоод аудит, андеррайтинг, нөхөн төлбөр, харилцагчийн гомдол шийдвэрлэх, хөрөнгө оруулалт болон шаардлагатай гэж үзсэн бодлого, журмыг баталж мөрдүүлнэ.

65.4. Компанийн засаглалыг хэрэгжүүлэхдээ Хорооноос баталсан Компанийн засаглалын кодексийг удиртгал болгоно.

65.5. Даатгагч нь үйл ажиллагаагаа бизнес төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

66 дугаар зүйл. Даатгагчийн бүтэц, зохион байгуулалт

66.1. Даатгагч нь даатгагчийн стратегийн зорилгууд болон үйл ажиллагааг дэмждэг, ойлгомжтой зохион байгуулалтын бүтэцтэй байна.

66.2. Даатгагч нь төлөөлөн удирдах зөвлөлийнхөө дэргэд Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасан байнгын аудитын хороо, гүйцэтгэх удирдлагын дэргэд дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын албыг тус тус ажиллуулна.

66.3. Даатгагч нь төлөөлөн удирдах зөвлөлийнхөө дэргэд цалин, урамшуулал, нэр дэвшүүлэх хороо, ёс зүйн хороо, хөрөнгө оруулалтын хороо, хөрөнгө, эх үүсвэрийн удирдлагын хороо, засаглалын хороо, стратегийн хороо, ил тод байдлын хороо, хүний нөөцийн хороотой байж болно.

67 дугаар зүйл. Даатгагчийн санхүүгийн болон бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэх

67.1. Даатгагч энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан аудитаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд хэвлэлээр болон өөрийн цахим хуудсаар, улирлын санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын дотор өөрийн цахим хуудсаар мэдээлнэ.

67.2. Даатгагч төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх удирдлагын гарын үсгээр баталгаажсан дараах мэдээллийг өөрийн цахим хуудсанд байршуулах замаар нийтэд мэдээлнэ:

67.2.1. даатгагчийн жилийн үйл ажиллагааны тайлан;

67.2.2. даатгагчийн компанийн засаглалын тайлан;

67.2.3. Хорооноос даатгагчийн эрсдэлийг тодорхойлоход шаардлагатай гэж үзсэн, нийтэд мэдээлэхээр шийдвэрлэсэн бусад мэдээлэл.

67.3. Даатгагч нь дараах мэдээллийг өөрийн цахим хуудсандаа тогтмол байршуулж, олон нийтэд мэдээлнэ:

67.3.1. хуулийн этгээдийн эрх зүйн хэлбэр, зохион байгуулалтын бүтэц, бүрэлдэхүүн, хяналтын тогтолцоо;

67.3.2. даатгагчийн төлбөрийн чадвар, хохирлын харьцаа, хосолсон харьцаа;

67.3.3. нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын овог нэр, мэргэжил, мэргэшсэн байдал, ажлын туршлагын талаарх мэдээлэл;

67.4. Хороо нь даатгагчийн олон нийтэд мэдээлсэн тайлан, мэдээллийн үнэн, зөв байдалд хяналт тавьж ажиллана.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

68 дугаар зүйл. Зах зээлийн зохистой үйл ажиллагаа

68.1. Хороо даатгалын салбарын дагаж мөрдвөл зохих зах зээлийн зохистой үйл ажиллагааны журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан болон даатгалын үйл ажиллагаанд оролцогч түүнийг дагаж мөрдөх үүрэгтэй.

68.2. Даатгагч нь даатгуулагч болон түүний эрх бүхий этгээдэд нөхөн төлбөр олгохоос бусад тохиолдолд аливаа төлбөр, тэдгээртэй адилтгах шан харамжийг шууд болон бусад этгээдээр дамжуулан олгохыг хориглоно.

69 дүгээр зүйл. Төөрөгдүүлсэн зар сурталчилгаа

69.1. Даатгагч нь төөрөгдүүлсэн, эсхүл худал мэдээлэл агуулсан зар сурталчилгаа, мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг гаргах, тараах, тараахыг зөвшөөрөхийг хориглоно.

69.2. Даатгагчийн болон түүний нэрийн өмнөөс гаргасан мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг нь төөрөгдүүлсэн буюу худал мэдээлэл агуулсан, эсхүл нийтийн ашиг сонирхолд харшилсан гэж үзвэл Хороо тухайн баримт бичгийг гаргахыг хориглох, няцаахыг даалгах, эсхүл шаардлагатай гэж үзсэн өөрчлөлт, залруулга хийж гаргахыг бичгээр даалгана.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ ДААТГАЛЫН МЭДЭЭЛЛИЙН САН

70 дугаар зүйл. Даатгалын мэдээллийн санг зохицуулах

70.1. Даатгалын мэдээллийн санг удирдах этгээд нь Заавал даатгалын холбоо байна.

70.2. Даатгалын мэргэжлийн оролцогчид нь хууль тогтоомжид заасан холбогдох мэдээллийг даатгалын мэдээллийн сан /цаашид “мэдээллийн сан” гэх/-д төвлөрүүлэх үүрэгтэй.

70.3.Мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх, хуваарилах, боловсруулах, удирдах, ашиглуулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах журмыг Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан Хороо батална.

70.4.Заавал даатгалын холбоо нь мэдээллийн санг удирдах үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

70.4.1.даатгалын зах зээлийг хөгжүүлэх аливаа үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэдээллийг боловсруулах;

70.4.2.мэдээллийн аюулгүй байдлыг хангах;

70.4.3.зах зээлийн шударга өрсөлдөөнийг хангах;

70.4.4.нийтийн ашиг, сонирхлыг зөрчихгүй байх, бусад этгээдэд давуу эрх олгохгүй байх.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХЯНАЛТ ШАЛГАЛТ, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, ТАЙЛАГНАХ

71 дүгээр зүйл. Үйл ажиллагааны шалгалтад хамаарах этгээд

71.1.Хороо энэ хуулийн дагуу дараах этгээд болон тэдгээрийн холбогдох этгээдийн үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтэд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ:

71.1.1.даатгагч;

71.1.2.энэ хуулийн 59.1.2-т заасан хөндлөнгийн хохирол үнэлэгч;

71.1.3.энэ хуулийн 20.2.1-д заасан Заавал даатгалын холбоо.

71.1.4.хууль тогтоомжид заасан бусад этгээд;

71.2.Хороо энэ хуулийн 71.1-д заасан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, албадлагын арга хэмжээ авахтай холбогдсон харилцааг зохицуулах журам баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

71.3.Энэ хуулийн 71.1-д заасан хяналт, шалгалтыг Хорооны даргын баталсан шалгалтын удирдамжийн дагуу хэрэгжүүлэх ба удирдамжийг хяналт, шалгалтад хамрагдах этгээдэд урьдчилан танилцуулна.

71.4.Хороо шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагааны шалгалтыг хэрэгжүүлэхдээ тохирох мэргэшсэн, дадлага туршлага, мэргэжил бүхий этгээдийг татан оролцуулж болно.

71.5.Хороо энэ хуулийн 71.1-д заасан хяналт, шалгалтад хамрагдах этгээдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг хэдийд ч авч хэрэгжүүлж болно:

71.5.1.үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, холбогдох баримт бичгийг шалгах;

71.5.2.шалгалтад хамрагдах этгээдийн хяналт болон эзэмшилд буй эд хөрөнгө, мөнгөн хөрөнгийн байршлыг хянаж шалгах;

71.5.3.нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон бусад баримт бичгийг хуулбарлан авч хянаж шалгах;

71.5.4.үйл ажиллагаанд ашиглаж буй программ хангамж, аливаа техник технологийн талаар болон түүнд агуулагдах мэдээ, мэдээлэл, холбогдох материалыг шалгах.

71.6.Хороо энэ хуульд заасан хяналт шалгалтын зарим чиг үүргээ тухайн чиглэлээр мэргэшсэн этгээдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

72 дугаар зүйл. Хяналт, шалгалттай холбоотой этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтны үүрэг

72.1.Энэ хуулийн 71.1-д заасан хяналт, шалгалтад хамрагдах этгээд шалгалтад хамрагдахтай холбоотой дараах үүрэг хүлээнэ:

72.1.1.хяналт шалгалтын үйл ажиллагааг бие даасан, хараат бусаар явуулах нөхцөлөөр хангах;

72.1.2.өөрийн байранд нэвтрэх, эд хөрөнгийг шалгах боломжоор хангах;

72.1.3.нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон холбогдох бусад баримт бичгийг гаргаж өгөх;

72.1.4.шаардлагатай мэдээ, мэдээлэл, тайлбарыг баримтаар болон цахим хэлбэрээр саадгүй, бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгөх;

72.1.5.үйл ажиллагаандаа ашиглаж буй программ хангамж, аливаа техник технологийн талаар болон түүнд агуулагдах мэдээ, мэдээлэл, холбогдох материалыг бэлтгэж өгөх;

72.1.6.шаардлагатай баримт бичгийг бусад этгээдээс олж авч Хороонд өгөх;

72.1.7.Хороо, түүний хянан шалгагчийн хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд шаардсан баримт, мэдээ мэдээлэл байхгүй бол хяналт, шалгалтад хамрагдах этгээд энэ тухайгаа албан бичгээр мэдэгдэх.

72.1.8.шалгалт хийж буй этгээдийн нэр хүндэд халдахгүй байх, хууль бус нотолгоогүй мэдээ мэдээллийг аливаа хэлбэрээр тараахгүй байх;

72.1.9.хууль тогтоомжид заасан бусад үүрэг;

72.2.Хороо энэ хуулийн 71.1-д заасан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх явцад шаардлагатай мэдээлэл, тайлбарыг шалгалтанд хамрагдах этгээдийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтнаас аливаа хэлбэрээр авч болно.

73 дугаар зүйл. Нэгдсэн хяналт шалгалт

73.1. Хороо нь энэ хуулийн 71.1-д заасан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэхдээ шаардлагатай гэж үзвэл холбогдох төрийн байгууллагатай хамтран нэгдсэн хяналт шалгалтыг хийх бөгөөд түүнд хамрагдах хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгдсэн байдлаар гаргаж үнэлэлт, дүгнэлт өгнө.

73.2. Энэ хуулийн 73.1-т заасан нэгдсэн хяналт шалгалтад тусгай зөвшөөрөл эзэмшигчийн холбогдох этгээдийг хамруулах, тэдгээрийн санхүүгийн тайлан, холбогдох бусад мэдээллийг гаргаж тайлагнах, хяналт шалгалт хийх харилцааг холбогдох төрийн байгууллагатай хамтран баталсан удирдамжийн дагуу зохицуулна.

73.3. Холбогдох этгээд нь өөр улсад бүртгэгдсэн буюу байршдаг бол Хороо тухайн орны эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцох болон бусад хэлбэрээр хамтран ажиллаж нэгдсэн хяналт, шалгалтыг хэрэгжүүлж болно.

73.4. Хорооноос шаардсан мэдээллийг тогтоосон хугацаанд тухайн холбогдох этгээд өөрөө, эсхүл тусгай зөвшөөрөл эзэмшигчээр дамжуулан гаргаж өгнө.

74 дүгээр зүйл. Шалгалтын тайлан

74.1.Хороо нь үйл ажиллагааны шалгалт дууссанаас хойш ажлын 45 хоногийн дотор шалгалтын товч тайланг шалгалтад хамрагдах этгээдэд хүргүүлнэ.

74.2.Шалгалтын тайланд дараах зүйлийг тусгана:

74.2.1.шалгалтад хамрагдах этгээдийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, хяналт болон шаардлагатай гэж үзсэн бусад асуудлын талаарх зөвлөмж, дүгнэлт;

74.2.2.тайлантай холбогдуулан шалгалтад хамрагдах этгээдээс хариу шаардаж байгаа эсэх, хариу шаардаагүй бол тайланд онцгойлон үзэж буй асуудлын талаар.

74.3.Шалгалтын тайлантай холбогдуулан хариу шаардсан, эсхүл албан шаардлага өгсөн бол шалгалтад хамрагдсан этгээд тайлан, албан шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор, эсхүл тэдгээрт тусгайлан заасан хугацаанд Хороонд хариу мэдэгдэх үүрэгтэй.

75 дугаар зүйл. Хорооны мэдээлэл цуглуулах эрх

75.1.Хороо энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор, эсхүл гадаадын зохицуулах байгууллагын тавьсан хүсэлтийн дагуу энэ хуулийн 75.2-т заасан этгээдээс дараах зүйлийг бичгээр шаардаж болно:

75.1.1.тодорхой төрлийн буюу тусгайлан заасан мэдээлэл гаргаж өгөхийг;

75.1.2.тодорхой төрлийн буюу тусгайлан заасан баримт бичиг гаргаж өгөхийг.

75.2.Энэ хуулийн 75.1-д заасан мэдэгдлийг холбогдох этгээд болон түүнтэй хамаарал бүхий этгээд, даатгагч, эсхүл мэдэгдэлтэй холбоотой мэдээлэл, баримт бичиг байгаа гэж үзсэн этгээдэд өгөх бөгөөд мэдэгдэлд мэдээлэл, баримт бичгийг гаргаж өгөх буюу үйлдэх хугацаа, газрыг заана.

75.3.Энэ хуулийн 75.2-т заасан "хамаарал бүхий этгээд"-ийг Хорооноос баталсан журмаар тодорхойлж, нэгдсэн бүртгэл хөтөлнө.

75.4.Хороо энэ хуулийн 75.1-д заасан эрхээ хэрэгжүүлэхдээ дараах шаардлагыг тавьж болно:

75.4.1.тогтоосон хэлбэр, загвараар мэдээлэл бэлтгэж ирүүлэхийг;

75.4.2.уг мэдээлэл, баримт бичгээ баталгаажуулахыг;

75.4.3.уг мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан тайлбар гаргахыг.

75.5. Хороо энэ хуульд заасны дагуу мэдээлэл цуглуулахдаа холбогдох баримт бичгийг түүвэрлэн буюу хуулбарлан авч болно.

75.6. Хорооноос энэ хуулийн 75.1-д заасны дагуу мэдээлэл, баримт бичгээр хангахыг даалгасан мэдэгдлийг хүлээн авсан этгээд нь өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн нөхцөл байдалтай холбоотой бүхий л баримт материал, тайлан бүртгэл, мэдээ, мэдээлэл, холбогдох бусад баримт бичгийг Хорооны шаардсанаар гарган өгөх үүрэгтэй.

76 дугаар зүйл. Гадаадын зохицуулах байгууллагад туслалцаа үзүүлэх

76.1.Гадаадын зохицуулах байгууллага өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан туслалцаа үзүүлэхийг бичгээр хүссэн тохиолдолд Хороо энэ хуулийн 76 дугаар зүйлд заасны дагуу холбогдох, мэдээлэл, баримт бичгээр хангаж болно.

76.2.Гадаадын зохицуулах байгууллагыг мэдээлэл, бичиг баримтаар хангах эсэхийг шийдвэрлэхдээ дараах асуудлыг анхаарна:

76.2.1.гадаадын зохицуулах байгууллага нь уг асуудалтай төстэй асуудлаар харилцан туслалцаа үзүүлж байсан, эсхүл үзүүлэх эсэх;

76.2.2.Монгол Улсын хууль тогтоомж, нийтийн ашиг сонирхолд нийцэж байгаа эсэх;

76.2.3.асуудлын шинж чанар, тухайн асуудал Монгол Улсын хувьд ач холбогдолтой эсэх;

76.2.4.мэдээлэл бэлтгэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг гадаадын зохицуулах байгууллага төлсөн эсэх;

76.2.5.энэ хуулийн 90 дүгээр зүйлд заасны дагуу мэдээллийн нууцлалыг хангаж чадах эсэх.

76.3.Хороо гадаадын зохицуулах байгууллагын хүссэн мэдээлэлтэй холбогдуулж тодруулга ирүүлэхийг уг байгууллагаас хүсэж болно.

76.4.Гадаадын зохицуулах байгууллага энэ хуулийн 76.3-т заасан хүсэлтэд хариу ирүүлээгүй бол Хороо түүнд туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно.

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ АЛБАДЛАГА

77 дугаар зүйл. Албадлагын арга хэмжээ авах үндэслэл

77.1.Хороо дараах үндэслэлээр даатгагчид албадлагын арга хэмжээ авч болно:

77.1.1.энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Даатгалын журмыг зөрчсөн;

77.1.2.даатгуулагчийн болон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулахуйц нөхцөл байдал үүссэн;

77.1.3.даатгагч төлбөрийн чадваргүй болсон буюу төлбөрийн чадваргүй болж болзошгүй гэж үзвэл;

77.1.4.Даатгалын нөөцийг энэ хууль болон Даатгалын журмын дагуу байгуулаагүй, уг хууль тогтоомжид заасан шаардлагыг биелүүлээгүй;

77.1.5.Хорооноос энэ хуулийн 83 дугаар зүйлд заасны дагуу өгсөн даалгаврыг биелүүлээгүй;

77.1.6.тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн;

77.1.7.тусгай зөвшөөрөл эзэмшигч, түүний удирдах албан тушаалтан, компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшиж буй этгээд нь тус тус тохиромжтой бус этгээд гэж үзсэн;

77.1.8.даатгагч татан буугдах хүсэлт гаргасан;

77.1.9.нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангаа хууль тогтоомжид нийцүүлж хөтлөөгүй, тайлагнаагүй;

77.1.10.даатгалын үйл ажиллагааг зохих журмын дагуу явуулаагүй;

77.1.11.холбогдох этгээдийн үйл ажиллагааг шалгах явцад Хороотой хамтран ажиллахаас татгалзсан;

77.1.12.энэ хуулийн 49.2, 53.2-т заасан шаардлагыг биелүүлээгүй, эсхүл давхар даатгалын төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллаагүй;

77.1.13.хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

78 дугаар зүйл. Албадлагын арга хэмжээний төрөл

78.1.Хороо энэ хуулийн 77.1-д заасан үндэслэлээр дараах төрлийн албадлагын арга хэмжээг хэрэглэнэ:

78.1.1.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх;

78.1.2.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;

78.1.3.энэ хуулийн 83 дугаар зүйлд заасны дагуу даалгавар өгөх;

78.1.4.энэ хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу шалгагч томилох;

78.1.5.даатгалын үйл ажиллагааг зохистой явуулах талаар зөвлөх үүрэг бүхий дадлага туршлагатай мэргэжилтэн томилох.

79 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх

79.1.Хороо тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр түдгэлзүүлнэ:

79.1.1.энэ хуулийн 77.1-д заасан үндэслэлийн аль нэг нь илэрсэн;

79.1.2.тусгай зөвшөөрлийн жил бүрийн төлбөрийг төлөх хугацаа өнгөрснөөс хойш 2 сарын дотор төлөөгүй.

79.2.Тусгай зөвшөөрлийг дараах хугацаагаар түдгэлзүүлнэ:

79.2.1.Хорооноос тогтоосон хугацаагаар;

79.2.2.Хорооноос тавьсан шаардлага, өгсөн даалгаврыг биелүүлэх хүртэл.

79.3.Энэ хуулийн 79.2.1-д заасан хугацаа нь 6 сараас хэтрэхгүй.

79.4.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхээс өмнө Хороо Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасан сонсох ажиллагаа явуулна.

79.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 79.4-т заасан сонсох ажиллагааны мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Хороонд бичгээр ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

79.6.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тохиолдолд дараах агуулга бүхий мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлнэ:

79.6.1.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай;

79.6.2.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн үндэслэл, түдгэлзүүлж эхэлсэн огноо;

79.6.3.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаа.

79.7.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн үндэслэл, нөхцөл, шаардлага арилсан тохиолдолд Хороо нь уг тусгай зөвшөөрлийг сэргээнэ.

80 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

80.1.Хороо дараах үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

80.1.1.тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

80.1.2.даатгалын компани татан буугдсан, эсхүл дампуурсан;

80.1.3.тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

80.1.4.тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

80.1.5.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй, тусгай зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй;

80.1.6.тусгай зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын дотор үйл ажиллагаагаа эхлээгүй, эсхүл үйл ажиллагаагаа зогсоосон;

80.1.7.хуульд заасан бусад.

80.2.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохоос өмнө Хороо Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасан сонсох ажиллагааг явуулна.

80.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 80.2-т заасан сонсох ажиллагааны мэдэгдлийг уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Хороонд бичгээр ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

80.4.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд дараах агуулга бүхий мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлнэ:

80.4.1.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай;

80.4.2.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон үндэслэл, огноо.

81 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосноос үүсэх үр дагавар

81.1.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш даатгагч Хорооноос бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр дараах үйлдэл хийхийг хориглоно:

81.1.1.шинээр даатгалын гэрээ байгуулах;

81.1.2.тухайн өдрөөс өмнө байгуулсан даатгалын гэрээг шинэчлэх, өөрчлөх.

81.2.Шаардлагатай гэж үзвэл даатгагч нь даатгалын гэрээгээр хүлээсэн үүрэг, давхар даатгалын хураамжийн төлбөр болон гэрээнээс үүссэн бусад зардлыг төлөх төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ.

81.3.Хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон талаархи мэдээллийг Даатгалын журамд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

81.4.Энэ хуулийн 80.1.2-80.1.5-д заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш 3 жилийн дотор тухайн этгээд дахин тусгай зөвшөөрөл хүсэж, өргөдөл гаргах эрхгүй.

82 дугаар зүйл. Хороо даатгагчийн эд хөрөнгийг хамгаалах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргах

82.1.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон, эсхүл энэ хуулийн 79.1, 80.1-д заасан үндэслэл байна гэж үзвэл нийтийн болон даатгуулагчийн ашиг сонирхол, даатгагчийн өмч хөрөнгө, үйл ажиллагааг хамгаалах зорилгоор Хороо дор дурдсан асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно:

82.1.1.даатгагчаас нөхөн төлбөр гаргуулж даатгуулагчид олгуулах;

82.1.2.даатгагчийн эд хөрөнгийг шилжүүлэх, захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлэх, хязгаарлах;

82.1.3.хууль тогтоомжид заасан бусад.

82.2.Хороо энэ хуулийн 82.1-д заасан нэхэмжлэл гаргахдаа даатгагчид мэдэгдэх үүрэг хүлээхгүй.

82.3.Даатгагчийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлээгүй, эсхүл хүчингүй болгоогүй бол нэхэмжлэлийг энэ хуулийн 79.4, 80.2-т заасан тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгох тухай мэдэгдлийг даатгагчид өгөхөөс өмнө гаргаж болно.

82.4.Энэ хуулийн 82.1-д заасан нэхэмжлэлийн дагуу шүүх дараах арга хэмжээг хэрэгжүүлж болно:

82.4.1.даатгагч болон бусад этгээдийн эзэмшилд буй өмч хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах зэрэг хэлцэл хийхийг хориглосон шийдвэр гаргах;

82.4.2.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгохоос өмнө даатгагчийн үйл ажиллагааг удирдан зохицуулах бүрэн эрхт төлөөлөгчийг нэн даруй томилох;

82.4.3.компанийг татан буулгах;

82.4.4.даатгагчийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар мэдээлэл авахаар холбогдох этгээдийг дуудан ирүүлэх.

82.5.Шүүх энэ хуулийн 82.4.2-т заасан бүрэн эрхт төлөөлөгчийг томилохдоо түүний эрх хэмжээ, цалин хөлс, шүүх болон Хороонд тайлан мэдээ гаргаж өгөх журмыг тогтооно.

82.6.Шүүх бүрэн эрхт төлөөлөгчийн талаар дараах арга хэмжээг хэдийд ч авч болно:

82.6.1.эрх үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан даалгавар, зааварчилга өгөх;

82.6.2.эрх хэмжээг нь өөрчлөх;

82.6.3.бүрэн эрхийг нь дуусгавар болгох.

83 дугаар зүйл. Даалгавар

83.1.Хороо даатгагчид албадлагын арга хэмжээ авахдаа дараах агуулга бүхий даалгаврыг албан бичиг болон улсын байцаагчийн албан шаардлагаар өгнө:

83.1.1.даатгалын тодорхой ангилал, хэлбэр, төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг түр зогсоох;

83.1.2.даатгалын тодорхой ангилал, хэлбэр, төрөлтэй холбоотой шинээр гэрээ байгуулахыг хориглох;

83.1.3.байгуулсан даатгалын гэрээг өөрчлөхийг хориглох;

83.1.4.даатгалын нийт хураамжийн хэмжээг даалгаварт заасан хэмжээгээр тогтоох;

83.1.5.тодорхой төрлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулахыг хориглох;

83.1.6.тодорхой хугацааны дотор өөрийн эзэмшилд буй хөрөнгө оруулалтыг чөлөөлөх;

83.1.7.хуульд заасан хугацаанаас өмнө санхүүгийн хяналт шалгалт хийх, шалгалттай холбогдуулан актуарч болон бусад этгээдийг томилох;

83.1.8.шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг энэ хууль, бусад хууль тогтоомж, Даатгалын журамд зааснаас богино хугацаанд гаргаж өгөх;

83.1.9.бизнес төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

83.1.10.даатгуулагч болон хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шаардлагатай гэж үзсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

83.2.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон бол шаардлагатай гэж үзсэн бусад даалгаврыг өгч болно.

83.3.Энэ хуулийн 83 дугаар зүйлд заасны дагуу Хорооноос өгч буй аливаа даалгаврыг даатгагч биелүүлэх үүрэгтэй.

83.4.Тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон этгээдэд энэ хуулийн 83 дугаар зүйл нэгэн адил хамаарна.

84 дүгээр зүйл. Шалгагчийг томилох

84.1.Хороо энэ хуулийн 77.1-д заасан үндэслэлээр албадлагын арга хэмжээ авахдаа тухайн этгээдийн үйл ажиллагааг хянан шалгах үүрэг бүхий нэг буюу хэд хэдэн этгээдийг шалгагчаар томилж болно.

84.2.Энэ хуулийн 84.1-д заасны дагуу томилогдсон шалгагч нь дараах асуудлыг хянан шалгаж болно:

84.2.1.даатгагчийн үйл ажиллагаа, түүний шинж чанар;

84.2.2.даатгагчийн үйл ажиллагааны тодорхой асуудлууд;

84.2.3.даатгагчийн болон хувьцаа эзэмшигчдийн хяналт.

84.3.Шалгагч нь шаардлагатай гэж үзвэл тухайн этгээдийн үйл ажиллагаа болон компанийн нэгдлийн бусад гишүүдийн үйл ажиллагааг хэдийд ч шалгаж болно.

84.4.Шалгагчийн томилолтын хугацаа болон нөхцөлийг Хороо тогтооно.

АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШИЛЖҮҮЛЭХ, НЭГТГЭХ

85 дугаар зүйл. Даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх болон нэгтгэх

85.1.Даатгагч даатгалын үйл ажиллагаагаа шилжүүлэх болон нэгтгэх хүсэлтээ Хороонд гаргаж бичгээр зөвшөөрөл авна.

85.2.Хорооноос бичгээр зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд даатгагчид дараах зүйлийг хориглоно:

85.2.1.даатгагчийн үйл ажиллагааны аливаа хэсгийг бусад этгээдэд шилжүүлэх;

85.2.2.даатгагчийн үйл ажиллагааны аливаа хэсгийг бусад этгээдийн үйл ажиллагаатай нэгтгэх.

85.3.Энэ хуулийн 85 дугаар зүйлд заасны дагуу шилжүүлэх болон нэгтгэх тухай өргөдөл гаргах, өргөдлийг хянан шийдвэрлэхтэй холбогдсон үйл ажиллагааг Даатгалын журмаар зохицуулна.

85.4.Шилжүүлэх болон нэгтгэх тухай зөвшөөрлийг олгохоос өмнө Хороо дараах арга хэмжээг авч болно:

85.4.1.шилжүүлэх болон нэгтгэх нь зохимжтой эсэх талаар судлах;

85.4.2.даатгагч болон бусад этгээдээс шаардлагатай гэж үзсэн баримт бичиг, мэдээллийг шаардаж авах.

85.5.Энэ хуулийн 85.4.1-д заасныг Хороо буюу түүний эрх олгосон этгээд хэрэгжүүлэх бөгөөд зардлыг даатгагч хариуцна.

85.6.Хорооны зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагааны аливаа хэсгийг бусдад шилжүүлэх, эсхүл бусдын үйл ажиллагаатай нэгтгэх үр дагавар бүхий даатгагчийн байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

85.7.Хороо нь даатгалын үйл ажиллагааны аливаа хэсгийг бусдад шилжүүлэх болон нэгтгэх тухай гаргасан өргөдлийг нээлттэй хурлаар хэлэлцэж болох бөгөөд даатгагч болон бусад этгээдээс шаардлагатай нотлох баримт шаардаж болно.

АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ ДААТГАГЧИЙГ ТАТАН БУУЛГАХ

86 дугаар зүйл. Даатгагчийн дампуурал

86.1.Даатгагчид дампуурлын хэрэг үүсгэхтэй холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Дампуурлын тухай хуулийн дагуу зохицуулна.

86.2.Шүүх дараах асуудлын талаар Хороонд мэдэгдэх бөгөөд Хороо уг асуудлыг хэлэлцэхэд оролцох, тайлбар өгөх эрхтэй:

86.2.1.Дампуурлын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу даатгагчид дампуурлын хэрэг үүсгүүлэх тухай шүүхэд гаргасан нэхэмжлэл болон хүсэлт;

86.2.2.Дампуурлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу даатгагчид дампуурлын хэрэг үүсгэсэнтэй холбоотой гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гаргаж буй аливаа гомдол;

86.2.3.даатгагчийн дампууралтай холбоотой Дампуурлын тухай хуулийн дагуу шүүхээс шийдвэрлэж буй бусад асуудал.

86.3.Даатгагчид дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт гаргасан тохиолдолд Хороо Дампуурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан хэрэг гүйцэтгэгчийг түр томилуулахаар хүсэлт гаргаж болох бөгөөд түүнд тохирох мэргэжил, дадлага туршлага бүхий хүнийг санал болгож болно.

86.4.Даатгагч дампуурсан тухайгаа зарласан тохиолдолд Хороо тохирох мэргэжил, дадлага туршлага бүхий хүнийг хэрэг гүйцэтгэгчээр томилуулахаар шүүхэд санал тавих бөгөөд энэ тохиолдолд Дампуурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг үйлчлэхгүй.

86.5.Шүүх Хорооноос санал болгосон этгээдийг хэрэг гүйцэтгэгчээр томилж болно.

86.6.Хэрэг гүйцэтгэгч болон хэрэг гүйцэтгэгчээр түр томилогдсон этгээд нь Дампуурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байхаас гадна даатгалын компанийн үйл ажиллагааны онцлогийн талаар зохих мэдлэгтэй байна.

86.7.Хороо нь Дампуурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3, 4, 6 дахь заалтад заасан асуудлаар шийдвэр гаргах эрхтэй.

86.8.Хэрэг гүйцэтгэгч нь өөрийн үйл ажиллагааны тухай Хорооны шаардлагатай гэж үзсэн мэдээлэл, тайланг гаргаж өгөх үүрэгтэй.

86.9.Хороо хариуцагч болон хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагааны талаар шүүхэд хэдийд ч гомдол гаргах эрхтэй.

86.10.Хариуцагч нь даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа бол Дампуурлын тухай хуульд заасан аливаа хугацааг шүүх өөрийн үзэмжээр сунгах эрхтэй.

87 дугаар зүйл. Даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх

87.1.Дампуурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргаж байгаа, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг шүүхэд гаргаж буй этгээд нь уг хүсэлт, төлөвлөгөөний хуулбарыг Хороонд хүргүүлнэ.

87.2.Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг хэлэлцэж буй нэхэмжлэгчдийн хуралд Хороо оролцож саналаа илэрхийлэх эрхтэй.

87.3.Шүүх даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг Хорооны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр батлахгүй.

87.4.Шүүхээс даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг батлах үйл ажиллагаанд Дампуурлын тухай хуулийн 28 дугаар зүйл үйлчлэхгүй.

88 дугаар зүйл. Даатгагчийг татан буулгах

88.1.Даатгагчийг татан буулгахтай холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Иргэний хууль, Дампуурлын тухай хууль, Компанийн тухай хуулийн дагуу зохицуулна.

88.2.Даатгагчийг дараах тохиолдолд татан буулгана:

88.2.1.шүүхийн шийдвэрээр;

88.2.2.Хорооноос бичгээр зөвшөөрсөн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр.

88.3.Даатгагчийг татан буулгах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэр нь Хорооны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр хүчин төгөлдөр бус байна.

88.4.Энэ хуулийн 88.2-т зааснаас бусад тохиолдолд даатгагчийг татан буулгасан шийдвэр хүчин төгөлдөр бус байна.

88.5.Дараах тохиолдолд Хороо даатгалын компанийг татан буулгах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргана:

88.5.1.даатгалын компани төлбөрийн чадваргүй болсон;

88.5.2.даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

88.6.Хороо тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан хуулийн этгээдийг татан буулгуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргаж болно.

88.7.Даатгагчийг татан буулгахаар нэхэмжлэл гаргасан тухай шүүх Хороонд мэдэгдэх бөгөөд Хороо нэхэмжлэлтэй холбоотой аливаа асуудлыг хэлэлцэхэд оролцох, тайлбар өгөх эрхтэй.

88.8.Дампуурлын тухай хуулийн дагуу даатгагчийг татан буулгахад шүүх хяналт тавих бөгөөд Дампуурлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 1 дэх хэсэг үйлчлэхгүй.

89 дүгээр зүйл. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр даатгагчийг татан буулгах

89.1.Энэ хуулийн 88.2.2-т заасны дагуу гаргасан хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр даатгагчийг татан буулгах тухай өргөдөлд татан буулгах комиссын гишүүнээр томилуулахаар санал болгож буй этгээдийн нэрсийн жагсаалтыг хавсаргана.

89.2.Хороо хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр даатгагчийг татан буулгах зөвшөөрлийг дараах тохиолдолд олгохгүй:

89.2.1.даатгагчийн хөрөнгийн нийт үнэлгээнээс түүний хүлээсэн үүргийг хасаж үлдсэн хэсэг нь энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн доод хэмжээг хангахгүй;

89.2.2.татан буулгах комиссын гишүүнээр томилуулахаар санал болгож буй этгээд нь ийнхүү ажиллахад шаардлагатай ур чадвар, дадлага туршлагагүй.

89.3.Хувьцаа эзэмшигчдийн хурлаас даатгагчийг татан буулгах тухай тогтоолыг батлахдаа татан буулгах комиссыг томилно.

89.4.Татан буулгах комисс томилогдсон тухайгаа тогтоолд заасан хугацаанд Хороонд мэдэгдэх үүрэгтэй.

89.5.Татан буулгах комиссын эрх хэмжээг Хорооноос холбогдох хуульд нийцүүлэн тогтооно.

АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД

90 дүгээр зүйл. Мэдээллийн нууцлалыг хадгалах

90.1.Хороо болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтан нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараах этгээдтэй холбоотой аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно:

90.1.1.тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргасан этгээд;

90.1.2.даатгагч, эсхүл даатгагч байсан этгээд, тэдгээрийн хараат болон охин компани;

90.1.3.даатгуулагч, эсхүл даатгуулагч байсан этгээд.

90.2.Дараах тохиолдолд энэ хуулийн 90.1 дэх хэсэг хамаарахгүй:

90.2.1.тухайн этгээд өөрийн нууцыг задруулахыг бичгээр зөвшөөрсөн;

90.2.2.Хороо шаардсан;

90.2.3.шүүх болон прокурор, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажлын шаардлагаар тэдгээр байгууллагын удирдлага хүсэлт гаргасан;

90.2.4.энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор тухайн этгээд мэдэх шаардлагатай;

90.2.5.уг мэдээллийг олон нийт бусад эх сурвалжаас мэдэх боломжтой, эсхүл нэгэнт мэдээлэгдсэн;

90.2.6.тухайн мэдээлэлтэй холбогдох энэ хуулийн 90.1-д заасан этгээдийг таних боломжгүй байдлаар буюу мэдээллийг товчлол, эсхүл статистик тоо баримтаар мэдээлэх;

90.2.7.энэ хуулийн 76 дугаар зүйлд заасны дагуу гадаадын зохицуулах байгууллага бичгээр хүсэлт гаргасан.

91 дүгээр зүйл.Даатгагчид гомдол гаргах

91.1.Даатгуулагч нь аливаа даатгалын үйл ажиллагаатай холбоотой хууль болон гэрээгээр олгогдсон өөрийн эрх ашиг зөрчигдсэн гэж үзвэл даатгагчид амаар, утсаар, бичгээр, цахим шуудан болон цахим хуудас зэргээр гомдол гаргана.

91.2.Даатгагч нь даатгуулагчийн гаргасан гомдлыг хүлээн авч бүртгэснээс хойш шууд шийдвэрлэх боломжтой тохиолдолд ажлын 3 хүртэл өдөр, бусад гомдлыг 30 хүртэл хоногийн дотор шийдвэрлэж, хариуг мэдэгдэнэ.

91.3.Гомдол шийдвэрлэсэн шийдвэрийг даатгуулагч эс зөвшөөрсөн тохиолдолд Даатгалын омбудсманд гомдол гаргах эрхтэй талаар даатгагч нь даатгуулагчид мэдэгдэх үүрэгтэй.

91.4.Даатгуулагч нь даатгагчийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн, эсхүл гомдлыг шийдвэрлээгүй тохиолдолд гомдол шийдвэрлэх хугацаа дууссанаас хойш 5 сарын дотор Даатгалын омбудсманд гомдол гаргаж болно.

92 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх

92.1.Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн хооронд даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг Хороо урьдчилан шийдвэрлэнэ.

93 дугаар зүйл. Маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх

93.1.Арбитрын хэлэлцээртэй бол даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ.

93.2.Энэ хуулийн 93.1-д заасны дагуу маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх тохиолдолд энэ хуулийн 91, 92 дугаар зүйл хамаарахгүй.

94 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

94.1.Энэ хуулийг зөрчсөн төрийн албан хаагчийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

94.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

95 дугаар зүйл. Хорооны албан хаагчийн хязгаарлагдмал хариуцлага

95.1.Хорооны албан хаагч энэ хууль, холбогдох бусад хууль болон Даатгалын журамд заасан үүргээ шударга бусаар хэрэгжүүлсэн буюу санаатайгаар хэрэгжүүлээгүй болох нь тогтоогдсоноос бусад тохиолдолд хариуцлага хүлээхгүй.

96 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

96.1.Энэ хуулийг 20... оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. Монгол улсын Иргэний хуулийн 431 дүгээр зүйлийн 431.4 дэх хэсгийн “гэрээнд” гэсний өмнө “гэрээг бичгээр эсхүл цахимаар хийх бөгөөд уг” гэж, мөн хуулийн 438 дугаар зүйлийн “Даатгалын” гэсний өмнө “Сайн дурын” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол улсын Иргэний хуулийн 432 дугаар зүйлийн 432.1, 432.2 дахь хэсгийн “албан журмын” гэснийг “заавал” гэж, 441 дүгээр зүйлийн 441.1 дэх хэсгийн “эдлэх боловч даатгалын баталгаа олгохыг гагцхүү даатгуулагч шаардах эрхтэй” гэснийг “эдэлнэ.” гэж, 444 дүгээр зүйлийн 444.5 дахь хэсгийн “албан журмаар” гэснийг “заавал” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Монгол улсын Иргэний хуулийн 431 дүгээр зүйлийн 431.3 дахь хэсэг, 433 дугаар зүйл, 441 дүгээр зүйлийн 441.2 дахь хэсгийн “зөвхөн даатгалын баталгааг өөртөө авсан тохиолдолд” гэснийг, мөн зүйлийн 441.3 дахь хэсгийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 11.13 дугаар зүйлд доор дурдсан 6.4 дэх хэсгийг нэмсүгэй.

“6.4.Даатгагч Даатгалын тухай хуулийн 24-30 дугаар зүйлийг ямар нэг хэлбэрээр зөрчсөн гэж үзсэн дүгнэлтийг эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг зургаан мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 11.13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“2.Аливаа этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт буй хөрөнгө, амь нас, эрүүл мэнд, хариуцлага, ашиг сонирхлоо хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл авсан даатгагчид даатгуулаагүй бол хүнийг зургаан зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг зургаан мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 11.13 дугаар зүйлийн 6.3, 9.1 дахь хэсгийн “багц дүрмийг” гэснийг “журмыг” гэж, мөн зүйлийн 10, 15.9, 17.1 дэх хэсгийн “багц дүрэмд” гэснийг “журамд” гэж, 15.1, 15.9, 16 дэх хэсгийн “дүрмийн сангийн” гэснийг “хувь нийлүүлсэн хөрөнгийн” гэж, 15.2 дахь хэсгийн “нөөц санг” гэснийг “нөөцийг” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 11.13 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “энэ хэсэгт заасан” гэснийг, мөн зүйлийн 16 дахь хэсгийн “сан” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН
БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлд доор дурдсан 33.3 дэх хэсгийг нэмсүгэй.

“33.3. Даатгалын тухай хуулийн 91 дүгээр зүйлд заасан журмаар маргаан хянан шийдвэрлэж буй тохиолдолд энэ хуулийн 33.1 дэх хэсэг хамаарахгүй.”

2 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийн “18, 19, 20, 69, 70 дугаар зүйл” гэснийг “15, 16, 17, 79, 80 дугаар зүйл” гэж, 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийн “61, 62, 63, 64, 65” гэснийг “71, 72, 73, 74, 75” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**ҮРИЙН ТАРИАЛАНГИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. Үрийн тариалангийн даатгалын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 4 дүгээр зүйлийн 4.1, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “албан журмаар” гэснийг “заавал” гэж, 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн “албан журмын” гэснийг “заавал” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.2 дахь заалтын “арилжааны” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.6, 13.2.7 дахь заалтын “4.1.2” гэснийг “4.1.7” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

НОТАРИАТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. Нотариатын тухай хуулийн 24 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 24.4 дэх хэсэг нэмсүгэй:

“24.4.Энэ хуулийн 24.1-д заасан заавал даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, заавал даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журмыг Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.”

2 дугаар зүйл. Нотариатын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2 дахь хэсгийн “хариуцлагын албан журмын” гэснийг “заавал” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл.Өмгөөллийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 24.4 дэх хэсэг нэмсүгэй:

“24.4.Энэ хуулийн 24.1-д заасан заавал даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, заавал даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журмыг Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 28.5 дахь хэсэг нэмсүгэй:

“28.5.Энэ хуулийн 28.4-д заасан заавал даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, заавал даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журмыг Санхүүгийн зохицуулах хороо, Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл.Барилгын тухай хуулийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.5 дахь хэсэг нэмсүгэй:

“8.5. Энэ хуулийн 8.2-8.4-д заасан заавал даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, заавал даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журмыг Санхүүгийн зохицуулах хороо, Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.”

2 дугаар зүйл.Барилгын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.5 дахь заалтын “бол” гэснийг хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ
ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.2 дахь хэсэг нэмсүгэй:

“19.2.Энэ хуулийн 19.1-д заасан заавал даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, заавал даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журмыг Санхүүгийн зохицуулах хороо, Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 28 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 28.3 дахь хэсэг нэмсүгэй:

“28.3.Энэ хуулийн 28.1-д заасан заавал даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, заавал даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журмыг Санхүүгийн зохицуулах хороо, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.”

2 дугаар зүйл. Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3, 28.4 дэх заалтыг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл.Төмөр замын тухай хуулийн 32 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 32.3 дахь хэсэг нэмсүгэй:

“32.3.Энэ хуулийн 29.5, 32.1-д заасан заавал даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, заавал даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журмыг Санхүүгийн зохицуулах хороо, Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.10 дахь хэсэг нэмсүгэй:

“8.10.Энэ хуулийн 8.2-т заасан заавал даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, заавал даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журмыг Санхүүгийн зохицуулах хороо, Хөдөлмөр нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран батална.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. Усан замын тээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17.5 дахь хэсэг нэмсүгэй:

“17.5.Энэ хуулийн 17.1-17.3-д заасан заавал даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, заавал даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журмыг Санхүүгийн зохицуулах хороо, Усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. Иргэний нисэхийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 38¹ дугаар зүйлийг нэмсүгэй:

“38¹.1.Энэ хуулийн 16.4, 30.2, 36.1, 37.1, 38.1-д заасан заавал даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, заавал даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журмыг Санхүүгийн зохицуулах хороо, Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран батална.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь даатгалын зуучлагчид тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлж, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын зуучлагчийн үйл ажиллагааг зохицуулж, хяналт тавих, тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Даатгалын зуучлалын тухай хууль тогтоомж

2.1.Даатгалын зуучлалын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Даатгалын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Даатгалын зуучлалын үйл ажиллагаатай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Даатгалын тухай хуулийн дагуу зохицуулна.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн энэ хуулийн 3.2-т зааснаас бусад нэр томьёог Даатгалын тухай хуульд заасан утгаар ойлгоно.

3.2.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.2.1.“даатгалын зуучлалын үйл ажиллагаа” гэж даатгалын зуучлагч даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулах болон хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх үйл ажиллагааг;

3.2.2.“даатгалын зуучлагч” гэж даатгалын брокер, даатгалын төлөөлөгч;

3.2.3.“даатгалын брокер” гэж даатгуулагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, даатгуулагчийг даатгагчтай холбож өгөх, талуудад мэргэжлийн зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх, үүнийхээ төлөө хөлс авах эрхтэй, тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;

3.2.4.“даатгалын төлөөлөгч” гэж даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийх үүрэг бүхий даатгагчийн томилсон буюу эрх олгосон этгээдийг;

3.2.5.“гадаадын даатгалын брокер” гэж гадаад улсад үүсгэн байгуулагдаж, Монгол Улсад даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч үйл ажиллагаагаа хэрэгжүүлж буй даатгалын брокерыг;

3.2.6.“хамтын даатгал” гэж Даатгалын тухай хуулийн 4.1.3-т заасан үйл ажиллагааг;

3.2.7.“холбогдох этгээд” гэж Даатгалын тухай хуулийн 4.1.18-д заасан этгээдийг.

3.3.Даатгалын байгууллагад ажиллаж буй ажилтан энэ хуулийн 3.2.4-т заасан даатгалын төлөөлөгчид хамаарахгүй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨРӨӨС ЗОХИЦУУЛАХ

4 дүгээр зүйл. Даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

4.1.Даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь даатгалын зуучлалын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1.Даатгалын зуучлалын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах;

4.1.2.Засгийн газрыг даатгалын зуучлалын бодлогын зөвлөгөөгөөр хангах;

4.1.3.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

**5 дугаар зүйл. Даатгалын зуучлалын үйл ажиллагаанд
Зохицуулах байгууллагын эрх үүрэг**

5.1.Даатгалын зуучлалын үйл ажиллагааг зохицуулах, хянах эрхийг даатгалын асуудал хариуцсан Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Хороо" гэх/ хэрэгжүүлнэ.

5.2.Хороо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.2.1.Даатгалын зуучлалын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;

5.2.2.даатгалын зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар үүрэг, даалгавар өгөх, хариуцлага ногдуулах;

5.2.3.даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

5.2.4.даатгалын төлөөлөгчид эрх олгох, эрх хасах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

5.2.5.даатгалын брокерын тусгай зөвшөөрөлгүй, даатгалын төлөөлөгчийн эрх аваагүй үйл ажиллагаа явуулсан этгээдэд арга хэмжээ авах;

5.2.6.Даатгалын зуучлалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор даатгалын зуучлагчийн дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон журам, заавар, аргачлал /цаашид “даатгалын журам” гэх/-ыг батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

5.2.7.даатгалын брокерын эрх бүхий албан тушаалтныг тохиромжтой этгээд эсэхийг тодорхойлох журмыг батлах;

5.2.8.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

6 дугаар зүйл. Даатгалын журам

6.1.Даатгалын зуучлалын үйл ажиллагааг энэ хууль болон Хорооноос баталсан даатгалын журмаар зохицуулна.

6.2.Хороо даатгалын зуучлалын үйл ажиллагааг хянах, зохицуулах хүрээнд Даатгалын тухай хуулийн 14.2-т зааснаас гадна даатгалын дараах журмыг батална:

6.2.1.энэ хуульд заасан тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргах, түүнд тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт;

6.2.2.даатгалын зуучлагч, түүний үйл ажиллагаанд тавигдах нөхцөл шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт;

6.2.3.даатгалын зуучлагч энэ хуульд заасны дагуу санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, мэдээ гаргаж, тайлагнах;

6.2.4.салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан үйл ажиллагаа явуулах гадаадын даатгалын брокерт тавигдах нөхцөл, шаардлага;

6.2.5.даатгалын зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх;

6.2.6.цахим хэлбэрээр даатгалын зуучлалын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих.

6.3 Хороо даатгалын зуучлалын үйл ажиллагааг хөгжүүлэх, боловсронгуй болгох, даатгалын зуучлалын үйл ажиллагааг зохистой явуулах зорилгоор тусгайлан даатгалын журмыг өөрийн бүрэн эрхийн хүрээнд баталж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ

Нэгдүгээр дэд бүлэг Нийтлэг үндэслэл

7 дугаар зүйл. Даатгалын зуучлагчийн эрх, үүрэг

7.1. Даатгалын зуучлагч нь дараах эрх эдэлнэ:

7.1.1. даатгуулагчаас үнэн зөв, бүрэн, бодит мэдээлэл авах;

7.1.2. даатгагч болон даатгуулагчаас зуучлалын үйл ажиллагааны хөлс, шимтгэл авах;

7.2. Даатгалын зуучлагч нь дараах үүрэг хүлээнэ:

7.2.1. даатгалын зуучлалын үйл ажиллагааг мэргэжлийн, нээлттэй, ёс зүйтэй гүйцэтгэх;

7.2.2. ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд үйлчлүүлэгчид энэ талаар мэдэгдэх;

7.2.3. даатгалын гэрээ байгуулахаас өмнө даатгалын бүтээгдэхүүн, даатгалын гэрээнд заасан даатгах эрсдэл, даатгалын үнэлгээ, хураамж, даатгалын нөхөн төлбөр хэрхэн авах, даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзах нөхцөлийг даатгуулагчид энгийн ойлгомжтой түвшинд тайлбарлан өгөх;

7.2.4. даатгалын гэрээ болон хураамж төлсөн баримтыг даатгуулагчид бичгээр эсхүл цахимаар олгох;

7.2.5. даатгагчтай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын хураамжийг хүлээн авсан даруй даатгагчид шилжүүлэх;

7.2.6. даатгалын хураамж төлөх хугацаа, гэрээний сунгалтыг даатгуулагчид гэрээнд заасны дагуу тухай бүр мэдэгдэх;

7.2.7. даатгуулагчид даатгагчаа сонгох боломжийг олгох.

7.3. Энэ хуулийн 17.2.1-д заасан нэг даатгагчийг төлөөлөх даатгалын төлөөлөгчийн хувьд энэ хуулийн 7.2.7 дахь заалт хамаарахгүй.

8 дугаар зүйл. Цахим хэлбэрээр даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх

8.1. Даатгалын зуучлагч үйл ажиллагаагаа цахим хэлбэрээр эрхэлж болох бөгөөд цахим хэлбэрийн онцлог, цар хүрээнээс хамааран шаардлагатай тохиолдолд Хорооноос зөвшөөрөл олгосны үндсэн дээр зах зээлд нэвтрүүлнэ.

8.2. Цахим хэлбэрээр даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх, түүний зөвшөөрөл олгох, хэрэгжилтэнд хяналт тавих зорилгоор Хороо журам баталж болно.

Хоёрдугаар дэд бүлэг
Даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэх

9 дүгээр зүйл. Даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл

9.1.Даатгалын брокерын үйл ажиллагааг Хорооноос тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд эрхэлнэ.

9.2.Даатгалын брокерын үйл ажиллагаа нь дараах ангилалтай байна:

9.2.1.ердийн даатгалын брокер;

9.2.2.амьдралын даатгалын брокер;

9.2.3.давхар даатгалын брокер.

9.3.Даатгалын брокер нь энэ хуулийн 9.2-т заасан даатгалын брокерын үйл ажиллагааны ангиллыг дангаар нь, эсхүл хамтад нь эрхэлж болно.

10 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл хүсэх

10.1.Даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг Хороонд гаргана.

10.2.Хүсэлтэд эрхлэх үйл ажиллагааны ангиллыг зааж, Хорооноос тогтоосон загварын дагуу энэ хууль болон даатгалын журамд заасан баримт бичгийг хавсаргаж ирүүлнэ.

10.3.Хороо шаардлагатай гэж үзсэн нэмэлт мэдээлэл, баримт бичгийг хүсэлт гаргагчаас шаардаж болно.

11 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах

11.1.Хороо дараах шаардлагыг хангасан хүсэлт гаргагчид тусгай зөвшөөрлийг олгох бөгөөд тухайн ангиллаас хамааран нэмэлт шаардлага тавьж болно:

11.1.1.тусгай зөвшөөрөл олгосон нь энэ хуулийн 13 дугаар зүйлийг зөрчихөөргүй бол;

11.1.2.хүсэлт гаргагчийн эрх бүхий албан тушаалтан болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6.а-д заасан этгээд нь даатгалын брокерийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээд бол;

11.1.3.хүсэлт гаргагч нь тусгай зөвшөөрлийг олгосны дараа энэ хууль болон даатгалын журмыг дагаж мөрдөх бүрэн боломжтой гэдэг нь нотлогдож байна гэж үзвэл;

11.1.4.тухайн даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргагчийн удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн эх үүсвэр хангалттай гэж үзвэл;

11.1.5.хүсэлт гаргагчийн нэр нь даатгалын брокерын үйл ажиллагааг эрхэлнэ гэдгийг илэрхийлэхээр бол;

11.1.6.тусгай зөвшөөрөл олгох нь нийтийн болон даатгуулагчийн ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж үзвэл.

11.2.Хороо даатгалын брокерын үйл ажиллагааны цар хүрээ, ангилал, төрлөөс хамааран тусгай зөвшөөрөлд тавигдах нөхцөл, шаардлагыг хэдийд ч өөрчлөн тогтоож болно.

11.3.Тусгай зөвшөөрлийг бичгээр олгох бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана:

11.3.1.тусгай зөвшөөрлийг олгосон байгууллагын нэр;

11.3.2.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр хаяг;

11.3.3.эрхлэх үйл ажиллагааны хэлбэр,төрөл;

11.3.4.тусгай зөвшөөрлийн дугаар, олгосон огноо;

11.3.5.тусгай зөвшөөрөл олгосон байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга /тэмдэг/.

11.4.Даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгох бөгөөд уг тусгай зөвшөөрөл нь энэ хуулийн 41, 42 дугаар зүйлд заасны дагуу түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл хүчин төгөлдөр байна.

11.5.Хороо хүсэлт гаргагчид тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан бол энэ тухай бичгээр мэдэгдэж, татгалзсан үндэслэлийг заана.

11.6.Хороо хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 45 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

11.7.Хороо тусгай зөвшөөрөл олгосон тухай даатгалын журамд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

12 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэхийг хориглох

12.1.Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлгүйгээр аливаа этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

12.2.Энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон даатгалын брокер энэ хуулийн 12.1-д заасан даатгалын брокерын үйл ажиллагаа явуулах эрхгүй.

12.3.Даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.

13 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих хязгаарлалт

13.1. Даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь компанийн хэлбэртэй байна.

13.2. Даатгалын брокерын тусгай зөвшөөрөлтэй компанийн ажилтан, эрх бүхий албан тушаалтан болон компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж буй этгээдэд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг олгохгүй.

13.3. Даатгагч, хөндлөнгийн хохирол үнэлэгч, тэдгээрийн хараат болон охин компани, даатгалын төлөөлөгчид даатгалын брокерын тусгай зөвшөөрлийг олгохгүй.

13.4. Даатгагчийн эрх бүхий албан тушаалтанд даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, эрхийг олгохгүй бөгөөд уг этгээд нь даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчийн ажилтан буюу эрх бүхий албан тушаалтан байж болохгүй.

14 дүгээр зүйл. Гадаадын даатгалын брокерын үйл ажиллагаа

14.1. Гадаадын даатгалын брокер нь гагцхүү Хорооноос авсан зөвшөөрлийн үндсэн дээр Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын брокерын үйл ажиллагаа явуулах эрхтэй.

14.2. Гадаадын даатгалын брокер нь энэ хуулийн 14.1-д заасны дагуу Хорооноос зөвшөөрөл аваагүй тохиолдолд аливаа этгээд гадаадын даатгалын брокерыг төлөөлж дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

14.2.1. даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэх;

14.2.2. даатгалын брокерын үйл ажиллагаа явуулах зорилгоор сурталчилгаа, ухуулга хийх, эсхүл ийм зорилгоор албан газар нээх, ажиллуулах;

14.2.3. салбар, төлөөлөгчийн газар нээх, ажиллуулах.

14.3. Даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахыг хүсэж буй этгээд нь Хороонд хүсэлт гаргана.

14.4. Хүсэлтэд холбогдох даатгалын журамд заасан баримт бичгийг хавсаргана.

14.5. Хороо энэ хуулийн 14.1-д заасан зөвшөөрлийг хүссэн хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэхдээ нэмэлт мэдээлэл, баримт бичгийг хүсэлт гаргагчаас шаардаж болно.

14.6. Энэ хуулийн 14.1-д заасан зөвшөөрөл олгохдоо Хороо тодорхой нөхцөл, шаардлага тавьж болох бөгөөд эдгээр нөхцөл, шаардлагаа хэдийд ч өөрчлөн тогтоож болно.

15 дугаар зүйл. Даатгалын брокер хамтын даатгалын үйл ажиллагаанд оролцох

15.1. Даатгалын брокер нь Даатгалын тухай хуулийн 4.1.3-т заасан хамтын даатгалын үйл ажиллагааг зохион байгуулахад оролцож болно.

15.2. Даатгалын брокер нь хамтын даатгалын үйл ажиллагааг зохион байгуулах тохиолдолд тухайн даатгалын брокерын зохион байгуулалтын энэхүү үүрэг нь хамтын даатгалын гэрээ дуусгавар болсноор зогсоно.

15.3. Даатгалын брокер хамтын даатгалын үйл ажиллагаанд оролцохтой холбогдох нарийвчилсан зохицуулалтыг даатгалын журмаар тогтоож болно.

16 дугаар зүйл. Даатгалын брокерын засаглалын тогтолцоо

16.1. Даатгалын брокер нь даатгалын брокерын үйл ажиллагааг найдвартай, оновчтой удирдлагаар хангаж, бизнесийн үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээ, цогц байдалд нийцэх үр дүнтэй засаглалын тогтолцоог бий болгож, мөрдөж ажиллана.

Гуравдугаар дэд бүлэг Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх

17 дугаар зүйл. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагааны эрх

17.1. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд Хороо эрх олгох ба эрх олгох, олгохоос татгалзахтай холбогдох журмыг Хороо батална.

17.2. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа нь дараах төрөлтэй байна:

17.2.1. нэг даатгагчийг төлөөлөх;

17.2.2. хэд хэдэн даатгагчийг төлөөлөх.

17.3. Энэ хуулийн 17.2.1-д заасан даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг иргэнд, 17.2.2-т заасан даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хуулийн этгээдэд олгоно.

18 дугаар зүйл. Эрх авах тухай хүсэлт гаргах

18.1. Даатгагчаас даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх эрх авсан этгээд нь энэ хуулийн 17.1-д заасан эрх авах тухай хүсэлтийг даатгагчаар дамжуулан Хороонд гаргана.

18.2. Хүсэлтийг гаргахдаа Хорооноос тогтоосон загварын дагуу энэ хууль болон даатгалын журамд заасан баримт бичгийг хавсаргаж ирүүлнэ.

18.3. Хороо шаардлагатай гэж үзсэн нэмэлт мэдээлэл, баримт бичгийг хүсэлт гаргагчаас шаардаж болно.

19 дүгээр зүйл. Эрх олгох, олгохоос татгалзах

19.1. Хороо дараах шаардлагыг хангасан хүсэлт гаргагчид эрх олгох бөгөөд нэмэлт шаардлага тавьж болно:

19.1.1. эрх олгосон нь энэ хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, 13.3-т заасныг зөрчихөөргүй бол;

19.1.2.хүсэлт гаргагч нь даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээд бол;

19.1.3.хүсэлт гаргагч энэ хууль болон даатгалын журмыг дагаж мөрдөх бүрэн боломжтой гэдэг нь нотлогдож байна гэж үзвэл.

19.2.Хороо хүсэлт гаргагчид даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгосон тухай бичгээр мэдэгдэх бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана:

19.2.1.эрх олгосон иргэний овог, нэр, хуулийн этгээд бол компанийн нэр;

19.2.2.эрх олгосон этгээдийн регистрийн дугаар;

19.2.3.даатгалын төлөөлөл хэрэгжүүлэх даатгагчийн нэрс;

19.2.4.эрхлэх үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлага;

19.2.5.эрхийн дугаар, эрх олгосон огноо.

19.3.Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх эрх нь энэ хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу эрх хасах хүртэл хүчин төгөлдөр байна.

19.4.Хороо хүсэлт гаргагчид эрх олгохоос татгалзсан бол энэ тухай бичгээр мэдэгдэж, татгалзсан үндэслэлийг заана.

19.5.Хороо хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 15 хоногийн дотор эрх олгох эсэхийг шийдвэрлэнэ.

19.6.Хороо даатгалын төлөөлөгчийн эрх авсан этгээдийг нийтэд ил тод байршуулна.

20 дугаар зүйл. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглох

20.1.Хорооноос эрх аваагүй аливаа этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

20.2.Энэ хуулийн дагуу эрх хасагдсан этгээд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа явуулах эрхгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА

21 дүгээр зүйл. Хувь нийлүүлсэн хөрөнгө

21.1.Даатгалын брокерын хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны үйл ажиллагааны орлогоос бүрдүүлсэн мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд даатгалын холбогдох журмыг Хороо батална.

21.2.Энэ хуулийн 21.1-д заасан хувь нийлүүлсэн хөрөнгийг зээлийн хөрөнгөөр бүрдүүлэхийг хориглоно.

21.3.Даатгалын брокерын хувь нийлүүлсэн хөрөнгө энэ хуулийн 21.1-д заасан хэмжээнд хүрэхгүй болсон тохиолдолд энэ тухай Хороонд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

21.4.Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орох тухай бүрд Хороонд мэдэгдэж, бүртгүүлнэ.

22 дугаар зүйл. Хувьцаа шилжүүлэхэд тавих хяналт

22.1.Хувьцаа шилжүүлэхэд дараах шаардлага тавигдана. Үүнд:

22.1.1.хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах мөнгөн хөрөнгө нь хууль ёсны орлогын эх үүсвэрээс бүрдсэн байх;

22.1.2.хувьцаа эзэмшигч этгээд нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох шалгуурыг хангасан байна.

22.2.Хороо энэ хуулийн 21.4-т заасны дагуу бүртгэхдээ шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл, шаардлага тавьж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, АУДИТ

23 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлт болон санхүүгийн тайлан

23.1.Дараах этгээд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон даатгалын журамд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана:

23.1.1.энэ хуулийн 9.1-д заасан даатгалын брокер;

23.1.2.энэ хуулийн 17.2.2-т заасан хэд хэдэн даатгагчийг төлөөлөх даатгалын төлөөлөгч.

23.2.Даатгалын журамд өөрөөр заагаагүй бол Хороо энэ хуулийн 23.1-д заасан этгээдийн нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг тогтоож болно.

23.3.Санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-д болон энэ хуулийн 23.2-т заасны дагуу Хорооноос тогтоосон баримт бичгээс бүрдэнэ.

23.4.Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан хугацаагаар хадгалах бөгөөд хадгалах газрын хаягийг Хороонд бичгээр мэдэгдэнэ.

24 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэлийн стандарт мөрдөх

24.1.Энэ хуулийн 23.1-д заасан этгээд нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг дагаж мөрдөнө.

25 дугаар зүйл. Жил бүрийн санхүүгийн тайлан

25.1.Энэ хуулийн 23.1-д заасан этгээд нь жилийн эцсийн санхүүгийн тайлан болон даатгалын журамд заасан бусад бичиг баримтын хамт дараа оны эхний сард багтаан Хороонд ирүүлнэ.

25.2.Энэ хуулийн 9.1-д заасан даатгалын брокер нь аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангаа дараа оны нэгдүгээр улиралд багтаан Хороонд ирүүлнэ.

25.3.Энэ хуулийн 25.1, 25.2-т заасан тайланг Хороонд ирүүлээгүй тохиолдолд санхүүгийн тайланг өгөөгүйд тооцно.

26 дугаар зүйл. Улирал тутмын тайлан

26.1.Энэ хуулийн 23.1-д заасан этгээд нь улирал тутмын санхүүгийн тайлангаа дараа сарын 20-ны өдрийн дотор Хороонд тушаана.

26.2.Даатгалын журамд заасан баримт бичгийг ирүүлээгүй тохиолдолд санхүүгийн тайланг өгөөгүйд тооцно.

27 дугаар зүйл. Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагаа

27.1.Энэ хуулийн 9.1-д заасан даатгалын брокер нь санхүүгийн тайландаа заавал аудит хийлгэх бөгөөд санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдтэй холбогдох харилцааг Даатгалын тухай хуулиар зохицуулна.

27.2.Аудит хийх хуулийн этгээд нь өөрийн баталгаажуулсан дэлгэрэнгүй тайлан, түүний талаарх эцсийн дүгнэлтийг даатгалын журамд заасны дагуу энэ хуулийн 9.1-д заасан даатгалын брокерт хүргүүлнэ.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНД ТАВИГДАХ ХЯЗГААРЛАЛТ

28 дугаар зүйл. Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа

28.1.Даатгалын зуучлагч Даатгалын тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл аваагүй даатгагчтай хамтран үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

28.2.Энэ хуулийн 28.1-д заасан даатгалын зуучлагч гадаадын даатгагчтай хамтран ажиллахад хамаарахгүй.

28.3.Даатгалын төлөөлөгч зөвхөн иргэдэд зориулсан даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг зуучилна.

29 дүгээр зүйл. Даатгалын зуучлагчийн төлбөр, хөлс, хураамж

29.1.Даатгалын зуучлагч дор дурдсанаас бусад тохиолдолд даатгагчийн байгуулсан гэрээний дагуу төлөгдөж буй хураамжийг хүлээн авах, эзэмших, түүнтэй холбоотой хэлцэл хийхийг хориглоно:

29.1.1.даатгалын хураамжийг хүлээн авах, эзэмших, түүнтэй холбоотой хэлцэл хийхийг даатгагч зөвшөөрсөн;

29.1.2.Хорооноос эрх олгосон.

29.2.Хороо даатгалын ангилал, хэлбэр, төрлөөс хамааран даатгагчаас даатгалын зуучлагчид олгох борлуулалтын хөлс, орлогын шимтгэлийн хувь хэмжээ, хязгаарыг тогтоож болно.

30 дугаар зүйл. Мэдээллийг өөрчлөх

30.1.Даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэж байгаа этгээд, эсхүл даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх эрх хүсэж байгаа этгээд энэ хууль, даатгалын журамд заасны дагуу Хороонд гаргаж буй аливаа зөвшөөрөл хүссэн хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэхээс өмнө Хороонд ирүүлсэн мэдээлэл, баримтад өөрчлөлт орвол зөвшөөрөл хүссэн этгээд энэ тухай нэн даруй бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

ДОЛООДУГААР БҮЛЭГ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

31 дүгээр зүйл. Зах зээлийн зохистой үйл ажиллагаа

31.1.Даатгалын зуучлалын мэргэжлийн холбоо нь даатгалын зуучлагчийн дагаж мөрдвөл зохих мэргэжлийн ёс зүйн дүрэм гаргаж болно.

31.2.Даатгалын зуучлалын мэргэжлийн ёс зүйн дүрэмд дараах асуудлыг тусгасан байвал зохино:

31.2.1.дагаж мөрдөх мэргэжлийн ёс зүй;

31.2.2.даатгуулагчтай харилцах, мэдээлэл өгөх;

31.2.3.мэргэжлийн ёс зүйн зөвлөл /цаашид "Мэргэжлийн ёс зүйн зөвлөл" гэх/, бүтэц, бүрэлдэхүүн;

31.2.4.мэргэжлийн ёс зүй зөрчсөн талаарх гомдол, маргаан хянан шийдвэрлэх.

31.3.Мэргэжлийн ёс зүйн зөвлөл нь даатгалын мэргэжлийн ёс зүй зөрчсөн талаарх гомдол, маргааныг хүлээн авч, холбогдогч талуудаас гаргасан мэдээлэлд үндэслэн дүгнэлт гаргаж болно.

31.4.Мэргэжлийн ёс зүйн зөвлөл нь гаргасан дүгнэлтдээ үндэслэн энэ хуулийн 33, 34 дүгээр зүйлд заасан хяналт шалгалт хийлгүүлэх, 39 дүгээр зүйлд заасан Албадлагын арга хэмжээ авах талаар санал гаргах эрхтэй.

32 дүгээр зүйл. Төөрөгдүүлсэн зар сурталчилгаа

32.1.Даатгалын зуучлагч нь төөрөгдүүлсэн, эсхүл худал мэдээлэл агуулсан зар сурталчилгаа, мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад бичиг баримт гаргах, тараах, тараахыг зөвшөөрөхийг хориглоно.

32.2.Даатгалын зуучлагч болон түүний нэрийн өмнөөс гаргасан мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг нь төөрөгдүүлсэн буюу худал

мэдээлэл агуулсан, эсхүл нийтийн ашиг сонирхолд харшилсан гэж үзвэл Хороо тухайн баримт бичгийг гаргахыг хориглох, няцаахыг даалгах, эсхүл шаардлагатай гэж үзсэн өөрчлөлт, залруулга хийж гаргахыг бичгээр даалгана.

НАЙМДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТ ШАЛГАЛТ, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, ТАЙЛАГНАХ

33 дугаар зүйл. Үйл ажиллагааны хяналт шалгалт

33.1.Хороо энэ хуулийн дагуу даатгалын зуучлагч болон тэдгээрийн холбогдох этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

33.2.Хороо энэ хуулийн 33.1-д заасан хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг даатгалын журмаар зохицуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

33.3.Энэ хуулийн 33.1-д заасан хяналт, шалгалтыг Хорооны даргын баталсан шалгалтын удирдамжийн дагуу хэрэгжүүлэх ба удирдамжийг хяналт, шалгалтад хамрагдах этгээдэд урьдчилан танилцуулна.

33.4.Хороо шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагааны шалгалтыг хэрэгжүүлэхдээ тохирох мэргэшсэн, дадлага туршлага, мэргэжил бүхий этгээдийг татан оролцуулж болно.

33.5.Хороо энэ хуулийн 33.1-д заасан хяналт, шалгалтад хамрагдах этгээдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг хэдийд ч авч хэрэгжүүлж болно:

33.5.1.үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, холбогдох баримт бичгийг цаасаар болон цахим хэлбэрээр шалгах;

33.5.2.шалгалтад хамрагдах этгээдийн хяналт болон эзэмшилд буй эд хөрөнгө, мөнгөн хөрөнгийн байршлыг хянаж шалгах;

33.5.3.нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон бусад баримт бичгийг хуулбарлан авч хянаж шалгах;

33.5.4.үйл ажиллагаанд ашиглаж буй программ хангамж, аливаа техник технологийн талаар болон түүнд агуулагдах мэдээ, мэдээлэл, холбогдох материалыг шалгах;

33.5.5. цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

33.6.Хороо энэ хуульд заасан хяналт шалгалтын зарим чиг үүргээ тухайн чиглэлээр мэргэшсэн этгээдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

34 дүгээр зүйл. Нэгдсэн хяналт шалгалт

34.1.Хороо нь энэ хуулийн 33.1-д заасан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэхдээ шаардлагатай гэж үзвэл холбогдох төрийн байгууллагатай хамтран нэгдсэн хяналт

шалгалтыг хийх бөгөөд түүнд хамрагдах хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгдсэн байдлаар гаргаж үнэлэлт, дүгнэлт өгнө.

34.2.Энэ хуулийн 34.1-д заасан нэгдсэн хяналт шалгалтад тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчийн холбогдох этгээдийг хамруулах, тэдгээрийн санхүүгийн тайлан, холбогдох бусад мэдээллийг гаргаж тайлагнах, хяналт шалгалт хийх харилцааг холбогдох төрийн байгууллагатай хамтран баталсан удирдамжийн дагуу зохицуулна.

34.3.Холбогдох этгээд нь өөр улсад бүртгэгдсэн буюу байршдаг бол Хороо тухайн орны эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцох болон бусад хэлбэрээр хамтран ажиллаж нэгдсэн хяналт, шалгалтыг хэрэгжүүлж болно.

34.4.Хорооноос шаардсан мэдээллийг тогтоосон хугацаанд тухайн холбогдох этгээд өөрөө, эсхүл тусгай зөвшөөрөл эзэмшигчээр дамжуулан гаргаж өгнө.

35 дугаар зүйл. Хяналт, шалгалттай холбоотой этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтны үүрэг

35.1.Энэ хуулийн 33.1-д заасан хяналт, шалгалтад хамрагдах этгээд шалгалт хийхтэй холбоотой дараах үүрэг хүлээнэ:

35.1.1.хяналт шалгалтын үйл ажиллагааг бие даасан, хараат бусаар явуулах нөхцөлөөр хангах;

35.1.2.өөрийн байранд нэвтрэх, эд хөрөнгийг шалгах боломжоор хангах;

35.1.3.нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон холбогдох бусад баримт бичгийг гаргаж өгөх;

35.1.4.шаардлагатай мэдээ, мэдээлэл, тайлбарыг баримтаар болон цахим хэлбэрээр саадгүй, бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгөх;

35.1.5.үйл ажиллагаандаа ашиглаж буй программ хангамж, аливаа техник технологийн талаар болон түүнд агуулагдах мэдээ, мэдээлэл, холбогдох материалыг бэлтгэж өгөх;

35.1.6.шаардлагатай баримт бичгийг бусад этгээдээс авч Хороонд өгөх;

35.1.7.Хороо, түүний хянан шалгагчийн хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд шаардсан баримт, мэдээ мэдээлэл байхгүй бол хяналт, шалгалтад хамрагдах этгээд энэ тухайгаа албан бичгээр мэдэгдэх;

35.1.8.шалгалт хийж буй этгээдийн нэр хүндэд халдахгүй байх, хууль бус нотолгоогүй мэдээ мэдээллийг аливаа хэлбэрээр тараахгүй байх;

35.1.9.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

35.2.Хороо энэ хуулийн 33.1-д заасан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх явцад шаардлагатай мэдээлэл, тайлбарыг шалгалтанд хамрагдах этгээдийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтнаас аливаа хэлбэрээр авч болно.

36 дугаар зүйл. Шалгалтын тайлан

36.1.Хороо нь үйл ажиллагааны шалгалт дууссанаас хойш ажлын 45 хоногийн дотор шалгалтын товч тайланг холбогдох этгээдэд хүргүүлнэ.

36.2.Шалгалтын тайланд дараах зүйлийг тусгана:

36.2.1.шалгалтад хамрагдах этгээдийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, хяналт болон шаардлагатай гэж үзсэн бусад асуудлын талаарх зөвлөмж, дүгнэлт;

36.2.2.тайлантай холбогдуулан шалгалтад хамрагдах этгээдээс хариу шаардаж байгаа эсэх, хариу шаардаагүй бол тайланд онцгойлон үзэж буй асуудлын талаар.

36.3.Шалгалтын тайлантай холбогдуулан хариу шаардсан, эсхүл албан шаардлага өгсөн бол шалгалтад хамрагдах этгээд тайлан, албан шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор, эсхүл тэдгээрт тусгайлан заасан хугацаанд Хороонд хариу мэдэгдэх үүрэгтэй.

37 дугаар зүйл. Хорооны мэдээлэл цуглуулах эрх

37.1.Хороо энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор, эсхүл гадаадын зохицуулах байгууллагын тавьсан хүсэлтийн дагуу энэ хуулийн 37.2-т заасан этгээдээс дараах зүйлийг бичгээр шаардаж болно:

37.1.1.тодорхой төрлийн буюу тусгайлан заасан мэдээлэл гаргаж өгөхийг;

37.1.2.тодорхой төрлийн буюу тусгайлан заасан баримт бичиг гаргаж өгөхийг.

37.2.Энэ хуулийн 37.1-д заасан мэдэгдлийг холбогдох этгээд болон түүнтэй хамаарал бүхий этгээд эсхүл, мэдэгдэлтэй холбоотой мэдээлэл, баримт бичиг байгаа гэж үзсэн этгээдэд өгөх бөгөөд уг мэдэгдэлд мэдээлэл, баримт бичгийг гаргаж өгөх болон үйлдэх хугацаа, газрыг заана.

37.3.Энэ хуулийн 37.2-т заасан “хамаарал бүхий этгээд”-ийг Хорооноос баталсан даатгалын журмаар тодорхойлж, нэгдсэн бүртгэл хөтөлнө.

37.4.Хороо энэ хуулийн 37.1-д заасан эрхээ хэрэгжүүлэхдээ дараах шаардлагыг тавьж болно:

37.4.1.тогтоосон хэлбэр, загвараар мэдээлэл бэлтгэж ирүүлэхийг;

37.4.2.мэдээлэл, баримт бичгээ баталгаажуулахыг;

37.4.3.мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан тайлбар гаргахыг.

37.5.Хороо энэ хуульд заасны дагуу мэдээлэл цуглуулахдаа холбогдох баримт бичгийг түүвэрлэн буюу хуулбарлан авч болно.

37.6.Хорооноос энэ хуулийн 37.1-д заасны дагуу мэдээлэл, баримт бичгээр хангахыг даалгасан мэдэгдлийг хүлээн авсан этгээд нь өөрийн үйл ажиллагаа,

санхүүгийн нөхцөл байдалтай холбоотой бүхий л баримт материал, тайлан бүртгэл, мэдээ, мэдээлэл, холбогдох бусад баримт бичгийг Хорооны шаардсанаар гарган өгөх үүрэгтэй.

38 дугаар зүйл. Гадаадын зохицуулах байгууллагад туслалцаа үзүүлэх

38.1.Гадаадын зохицуулах байгууллага өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан туслалцаа үзүүлэхийг бичгээр хүссэн тохиолдолд Хороо энэ хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу холбогдох мэдээлэл, баримт бичгээр хангаж болно.

38.2.Гадаадын зохицуулах байгууллагыг мэдээлэл, баримт бичгээр хангах эсэхийг шийдвэрлэхдээ дараах асуудлыг анхаарна:

38.2.1.гадаадын зохицуулах байгууллага нь уг асуудалтай төстэй асуудлаар харилцан туслалцаа үзүүлж байсан, эсхүл үзүүлэх эсэх;

38.2.2.Монгол Улсын хууль тогтоомж, нийтийн ашиг сонирхолд нийцэж байгаа эсэх;

38.2.3.асуудлын шинж чанар, тухайн асуудал Монгол Улсын хувьд ач холбогдолтой эсэх;

38.2.4.мэдээлэл бэлтгэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг гадаадын зохицуулах байгууллага төлсөн эсэх;

38.2.5.энэ хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу мэдээллийн нууцлалыг хангаж чадах эсэх.

38.3.Хороо гадаадын зохицуулах байгууллагын хүссэн мэдээлэлтэй холбогдуулж тодруулга ирүүлэхийг уг байгууллагаас хүсэж болно.

38.4.Гадаадын зохицуулах байгууллага нь энэ хуулийн 38.3-т заасан хүсэлтэд хариу ирүүлээгүй бол Хороо түүнд туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ АЛБАДЛАГА

39 дүгээр зүйл. Албадлагын арга хэмжээ авах үндэслэл

39.1.Хороо дараах үндэслэлээр даатгалын зуучлагчид албадлагын арга хэмжээ авч болно:

39.1.1.энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомж, даатгалын журмыг зөрчсөн;

39.1.2.үйлчлүүлэгчийн болон нийтийн ашиг сонирхолд, даатгалын төлөөлөгчийн хувьд даатгагчийн ашиг сонирхолд хохирол учруулахуйц нөхцөл байдал үүссэн;

39.1.3.төлбөрийн чадваргүй болсон буюу төлбөрийн чадваргүй болж болзошгүй гэж үзвэл;

39.1.4.энэ хуулийн 44 дүгээр зүйлд заасны дагуу Хорооноос өгсөн даалгаврыг биелүүлээгүй;

39.1.5.тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олгох нөхцөл, шаардлагыг зөрчсөн;

39.1.6.тусгай зөвшөөрөл эзэмшигч, түүний удирдах албан тушаалтан, компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшиж буй этгээд нь тус тус тохиромжтой бус этгээд гэж үзсэн;

39.1.7.Хороонд бодитой бус, төөрөгдүүлсэн мэдээлэл өгсөн нь тогтоогдсон;

39.1.8.нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангаа хууль тогтоомжид нийцүүлж хөтлөөгүй, тайлагнаагүй;

39.1.9.хамаарал бүхий этгээдийн үйл ажиллагааг шалгах явцад Хороотой хамтран ажиллахаас татгалзсан;

39.1.10.энэ хуулийн 32.4-т заасны дагуу Мэргэжлийн ёс зүйн зөвлөл санал гаргасан;

39.1.11.хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

40 дүгээр зүйл. Албадлагын арга хэмжээний төрөл

40.1.Хороо энэ хуулийн 39.1-д заасан үндэслэлээр дараах төрлийн албадлагын арга хэмжээг хэрэглэнэ:

40.1.1.даатгалын брокерын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх;

40.1.2.даатгалын брокерын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;

40.1.3.даатгалын төлөөлөгчийн эрхийг хасах;

40.1.4.энэ хуулийн 44 дүгээр зүйлд заасны дагуу даалгавар өгөх;

40.1.5.энэ хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу шалгагч томилох;

40.1.6.даатгалын зуучлалын үйл ажиллагааг зохистой явуулах талаар зөвлөх үүрэг бүхий дадлага туршлагатай мэргэжилтэн томилох.

41 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх

41.1.Хороо тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр түдгэлзүүлнэ:

41.1.1.энэ хуулийн 39.1-д заасан үндэслэлийн аль нэг нь илэрсэн;

41.1.2.тусгай зөвшөөрлийн жил бүрийн төлбөрийг төлөх хугацаа өнгөрснөөс хойш 2 сарын дотор төлөөгүй.

41.2.Тусгай зөвшөөрлийг дараах хугацаагаар түдгэлзүүлнэ:

41.2.1.Хорооноос тогтоосон хугацаагаар;

41.2.2.Хорооноос тавьсан шаардлага, өгсөн даалгаврыг биелүүлэх хүртэл.

41.3.Энэ хуулийн 41.2.1-д заасан хугацаа нь 6 сараас хэтрэхгүй.

41.4.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхээс өмнө Хороо Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасан сонсох ажиллагаа явуулна.

41.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 41.4-т заасан сонсох ажиллагааны мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Хороонд бичгээр ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

41.6.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тохиолдолд дараах агуулга бүхий мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлнэ:

41.6.1.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай;

41.6.2.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн үндэслэл;

41.6.3.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж эхэлсэн огноо;

41.6.4.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаа.

41.7.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн үндэслэл, нөхцөл, шаардлага арилсан тохиолдолд Хороо уг тусгай зөвшөөрлийг сэргээнэ.

42 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, сэргээх

42.1.Хороо дараах үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

42.1.1.тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

42.1.2.тусгай зөвшөөрөл эзэмшигч татан буугдсан, эсхүл дампуурсан;

42.1.3.тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

42.1.4.тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

42.1.5.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй, тусгай зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй;

42.1.6.тусгай зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын дотор үйл ажиллагаагаа эхлээгүй, эсхүл үйл ажиллагаагаа зогсоосон;

42.1.7.хуульд заасан бусад.

42.2.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохоос өмнө Хороо Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасан сонсох ажиллагааг явуулна.

42.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 42.2-т заасан сонсох ажиллагааны мэдэгдлийг уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Хороонд бичгээр ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

42.4.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд дараах агуулга бүхий мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлнэ:

42.4.1.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай;

42.4.2.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон үндэслэл;

42.4.3.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон огноо.

42.5.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш 3 жилийн дараа тухайн этгээд дахин тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргах эрхтэй.

43 дугаар зүйл. Даатгалын төлөөлөгчийн эрхийг хасах, сэргээх

43.1.Хороо дараах үндэслэлээр даатгалын төлөөлөгчийн эрхийг хасна:

43.1.1.даатгалын төлөөлөгч хүсэлт гаргасан;

43.1.2.даатгагч хүсэлт гаргасан;

43.1.3.эрх авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

43.1.4.даатгалын төлөөлөгч нас барсан;

43.1.5.даатгалын журмыг удаа дараа зөрчсөн.

43.2.Эрхийг хасахаас өмнө Хороо эрхийг хасах болсон үндэслэлийг заасан мэдэгдлийг даатгагчид бичгээр хүргүүлж, хүргэсэн огноог тэмдэглэнэ.

43.3.Даатгагч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор эрхийг хасах нь үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Хороонд ирүүлээгүй бол эрхийг хасна.

43.4.Эрхийг хассан тохиолдолд дараах агуулга бүхий мэдэгдлийг даатгагчид бичгээр хүргүүлнэ:

43.4.1.эрхийг хассан тухай;

43.4.2.эрхийг хассан үндэслэл;

43.4.3.эрхийг хассан огноо.

43.5.Хороо эрхийг хассан тухай даатгалын журамд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

43.6.Эрхийг хассанаас хойш 1 жилийн дараа тухайн этгээд даатгалын төлөөлөгчийн эрх авах хүсэлт гаргах эрхтэй.

44 дүгээр зүйл. Даалгавар

44.1.Хороо даатгалын зуучлагчид албадлагын арга хэмжээ авахдаа дараах агуулга бүхий даалгаврыг албан бичиг болон улсын байцаагчийн албан шаардлагаар өгч болно:

44.1.1.даатгалын зуучлалын тодорхой хэлбэр, төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг түр зогсоох;

44.1.2.тодорхой хэлбэр, төрлийн үйл ажиллагаатай холбоотой шинээр гэрээ байгуулахыг хориглох;

44.1.3.байгуулсан даатгалын гэрээг өөрчлөхийг хориглох;

44.1.4.шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг энэ хууль, бусад хууль тогтоомж, даатгалын журамд зааснаас богино хугацаанд гаргаж өгөх;

44.1.5.даатгуулагч болон даатгалын төлөөлөгчийн хувьд төлөөлж буй даатгагчийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шаардлагатай гэж үзсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

44.2.Энэ хуулийн 44.1-д заасны дагуу Хорооноос өгч буй аливаа даалгаврыг даатгалын зуучлагч биелүүлэх үүрэгтэй.

44.3.Энэ хуулийн 44 дүгээр зүйл тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон, эрхийг хассан этгээдэд нэгэн адил хамаарна.

45 дугаар зүйл. Шалгагчийг томилох

45.1.Хороо энэ хуулийн 39.1-д заасан үндэслэлээр албадлагын арга хэмжээ авахдаа тухайн этгээдийн үйл ажиллагааг хянан шалгах үүрэг бүхий нэг буюу хэд хэдэн этгээдийг шалгагчаар томилж болно.

45.2.Энэ хуулийн 45.1-д заасны дагуу томилогдсон шалгагч нь дараах асуудлыг хянан шалгаж болно:

45.2.1.тухайн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, шинж байдал;

45.2.2.тухайн этгээдийн үйл ажиллагааны тодорхой асуудал;

45.2.3.тухайн этгээдийн болон хувьцаа эзэмшигчдийн хяналт.

45.3.Шалгагч нь шаардлагатай гэж үзвэл тухайн этгээдийн үйл ажиллагаа болон компанийн нэгдлийн бусад гишүүдийн үйл ажиллагааг хэдийд ч шалгаж болно.

45.4.Шалгагчийн томилолтын хугацаа болон нөхцөлийг Хороо тогтооно.

АРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

46 дугаар зүйл. Мэдээллийн нууцлалыг хадгалах

46.1.Хороо болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтан нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараах этгээдтэй холбоотой аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно:

46.1.1.тусгай зөвшөөрөл авах, эрх авах хүсэлт гаргасан этгээд;

46.1.2.даатгалын зуучлагч, эсхүл даатгалын зуучлагч байсан этгээд, тэдгээрийн хараат болон охин компани;

46.1.3.даатгуулагч, эсхүл даатгуулагч байсан этгээд.

46.2.Дараах тохиолдолд энэ хуулийн 46.1 дэх хэсэг хамаарахгүй:

46.2.1.тухайн этгээд өөрийн нууцыг задруулахыг бичгээр зөвшөөрсөн;

46.2.2.Хороо шаардсан;

46.2.3.шүүх болон прокурор, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажлын шаардлагаар тэдгээр байгууллагын удирдлага хүсэлт гаргасан;

46.2.4.энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор тухайн этгээд мэдэх шаардлагатай;

46.2.5.уг мэдээллийг олон нийт бусад эх сурвалжаас мэдэх боломжтой, эсхүл нэгэнт мэдээлэгдсэн;

46.2.6.тухайн мэдээлэлтэй холбогдох энэ хуулийн 46.1-д заасан этгээдийг таних боломжгүй байдлаар буюу мэдээллийг товчлол, эсхүл статистик тоо баримтаар мэдээлэх;

46.2.7.энэ хуулийн 38.1-д заасны дагуу гадаадын зохицуулах байгууллага бичгээр хүсэлт гаргасан.

47 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх

47.1.Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн хооронд даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг Хороо урьдчилан шийдвэрлэнэ.

48 дугаар зүйл. Маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх

48.1.Арбитрын хэлэлцээртэй бол даатгалын зуучлалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ.

48.2.Энэ хуулийн 48.1-д заасны дагуу маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх тохиолдолд энэ хуулийн 47 дугаар зүйл хамаарахгүй.

49 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

49.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

49.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

50 дугаар зүйл. Хорооны албан хаагчийн хязгаарлагдмал хариуцлага

50.1.Хорооны албан хаагч энэ хууль, холбогдох бусад хууль болон даатгалын журамд заасан үүргээ шударга бусаар хэрэгжүүлсэн буюу санаатайгаар хэрэгжүүлээгүй болох нь тогтоогдсоноос бусад тохиолдолд хариуцлага хүлээхгүй.

51 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

51.1.Энэ хуулийг 20... оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх заалтын “мэргэжлийн оролцогчийн” гэснийг “зуучлалын” гэж, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийн “8, 9, 10, 11, 12, 38, 39 дүгээр зүйлд” гэснийг “9, 10, 11, 12, 13, 41, 42 дугаар зүйлд” гэж, 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийн “30, 31, 32, 33, 34 дүгээр зүйлд” гэснийг “33, 34, 35, 36, 37 дугаар зүйлд” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “хохирол үнэлэгчийн” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Даатгалын зуучлалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 11.14 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1.Тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхэлсэн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Даатгалын зуучлагч дүрмийн сангийн доод хэмжээг хуульд заасны дагуу бүрдүүлээгүй, эсхүл дүрмийн сан хуульд заасан хэмжээнд хүрэхгүй болсон тохиолдолд эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Даатгалын зуучлагчийн гаргаж буй бүх хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийсэн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Даатгалын зуучлагч нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтлөөгүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Хуульд заасан шаардлага хангаагүй аудиторыг томилсон бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Даатгалын зуучлагч тусгай зөвшөөрөл аваагүй даатгагчтай хамтран үйл ажиллагаа явуулсан, эсхүл хуульд зааснаас бусад тохиолдолд даатгагчийн байгуулсан гэрээний дагуу төлөгдөж буй хураамжийг хүлээн авсан, эсхүл эзэмшсэн, эсхүл түүнтэй холбоотой хэлцэл хийсэн, эсхүл хуульд заасны дагуу хүргүүлсэн эрх бүхий байгууллагын даалгаврыг биелүүлээгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Эрх бүхий байгууллагаас явуулж буй шалгалтын үед холбогдох этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтан хуульд заасан үүргээ биелүүлээгүй, эсхүл шалгалтын тайлантай холбогдуулан эрх бүхий байгууллагаас хариу шаардсан бол холбогдох этгээд тайланг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор, эсхүл тайланд тусгайлан заасан хугацаанд эрх бүхий байгууллагад хариу мэдэгдэх, эсхүл эрх бүхий байгууллагаас бичгээр шаардсан зүйлийг хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8. Даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэж байгаа этгээд, эсхүл даатгалын зуучлагч болон бусад этгээдээс хууль, даатгалын багц дүрэмд заасны дагуу эрх бүхий байгууллагад гаргаж буй зөвшөөрөл хүссэн өргөдлийг хэлэлцэн шийдвэрлэхээс өмнө эрх бүхий байгууллагад ирүүлсэн мэдээлэл, баримтад өөрчлөлт орвол зөвшөөрөл хүссэн этгээд энэ тухай даруй бичгээр мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9. Даатгалын зуучлалын тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүй, эсхүл хориглосон хэм хэмжээг зөрчсөн, нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход шаардлагатай мэдээллийг даатгагчийн шаардсан хугацаанд гаргаж өгөөгүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Даатгалын зуучлалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.3 дахь заалтын “даатгалын мэргэжлийн оролцогчийн” гэснийг “даатгалын брокер, банк даатгалын зуучлагчийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Даатгалын зуучлалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ
ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “даатгалын мэргэжлийн оролцогч” гэснийг “даатгалын брокер, банк даатгалын зуучлагч” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Даатгалын зуучлалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “даатгалын мэргэжлийн оролцогчийн” гэснийг “даатгалын зуучлалын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Даатгалын зуучлалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ